

УЛС ТӨР

☉ Ч.Өнөрбаяр: Сонгуулиас өмнө Засгийн газрын бүрэлдэхүүнийг шинэчлэх ёстой

➔ 2

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

☉ Монголдоо ирээд тусгаарлагдсан иргэдэд хэлэх хэдэн үг

➔ 7

ЭДИЙН ЗАСАГ

☉ Улс орнууд цар тахлын эсрэг арга хэмжээ авахдаа хугацаа алдаж байна

➔ 11

ZGM DAILY

☉ FULL ENGLISH PAGE INSIDE

➔ 20-21

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

TDB ONLINE
Банкны бүх төрлийн үйлчилгээг нэг дороос

2020.03.27, БААСАН~№048 (1327)

~ ИРГЭН БАЯН БОЛ УЛС БАЯН ~

₮1000, 24 НҮҮР

АЛТ	ЗЭС	ТӨМРИЙН ХҮДЭР	НЕФТЬ	ЧИНГИС БОНД	ХУРАЛДАЙ БОНД	ГЭРЭГЭ БОНД	САМУРАЙ БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ	ВОН
1,647.10 0.97%	4,814.00 3.97%	600.00 0.00%	46.83 23.30%	102.56	108.18	102.38	103.39	2773.00	390.84	35.72	2.25



ХЯМРАЛЫН ҮЕД ХАЛУУНЫГ АТГАХ ЧАДВАР ХҮН БҮРТ БАЙДАГГҮЙ. ХАРИН ЕРӨНХИЙЛӨГЧИД БОЛ БАЙНА

Манай улс төрийн намууд ямар ч тооцоо судалгаагүй атлаа сонгуулийн том том мөнгөн амлалт өгч байгаа нь оргүй худлаас гадна тэд цаг үеэ огт мэдрэхээ байсны шинж. Харин Ерөнхийлөгч энэ задгайралд цэг тавьж, нэгдсэн зохион байгуулалтаар хямралыг давж гаръя гэж хэллээ.

☉ Гэрэл зургийг С.Батсайхан

➔ 2

☉ Цахим мөрийтэй тоглоомын 20 гаруй серверийг шалгах эхэллээ

➔ 3

Иргэдийн онлайн покерт алдсан мөнгө 10 тэрбумаар тогтохгүй, цаашид нэмэгдэх хандлагатай байна.

☉ Шүдний эмнэлгийн стандартыг шинэчлэх шаардлагатай

➔ 4



☉ Монголын хөрөнгийн зах зээлийг COVID-19 чичиргэж эхэллээ

➔ 8

ТОП-20 индекс сүүлийн найман өдөр дараалан буурч, 2017 оны есөн сараас хойших хамгийн доод түвшинд хүрээд байна.

☉ Мишель Обама: Creed Love in White таашаадаг

➔ 13



Өнөөдөр	Маргааш
0°C ☀	7°C ☀
-15°C 🌙	-10°C 🌙



Шинжилгээний хариу эерэг гарвал авчрахгүй

➔ 5

#413 \$4.2 тэрбум

Лес Векснер, L Brands-ийн үүсгэн байгуулагч, АНУ-ын тэрбумтан

Шинэ санаа бүрээ нэтгэж, байнга туршилт хий. Аливааг бүтээнэ гэдэг нь зөвхөн биет зүйлээр хязгаарлагдах ёсгүй.



УЛС ТӨР

Хямралын үед халууныг атгах чадвар хүн бүрт байдаггүй, харин Ерөнхийлөгчид бол байна

Б.Сэлэнгэ, ЗГМ сонин

“Нэг хүний үхэл эмгэнэл, харин сая хүний үхэл бол статистик тоо баримт болдог” гэх хатуу үг бий.

Тэгвэл COVID-19 тахалд өртөөгүй улс манай гараг дээр бараг үлдэхгүй нь бололтой. Өвчилсөн хийгээд нас барсан иргэдийн тоо өдөрт хэдэн арван мянгаар яригдаж, бидний их гүрнүүд хэмээн нэрлэдэг хүчирхэг улс орнууд үүрээ эвдүүлсэн шоргоолж лугаа үймэлдэж байна.

Хятадын Уханьд эхэлснээс хойш эдийн засгаа бодох уу, хүнээ аварч үлдэх үү гэсэн хоёр сонголтыг л улс орнуудад энэ тахал тулгасан. Дорнын улсууд хүнээ нэгдүгээрт эрэмбэлсэн бол өрнийнхөн эдийн засгаа эхэнд нь тавьсны горьг өнөөдөр амсаж буй. Европ хийгээд Америк тивд иргэд нь тахлаар өвдөж, эдийн засаг нь ч элгээрээ хэвтэх гэж байна.

Тэгвэл өнөөдөр Монгол Улс ч гэсэн хоёр сонголттой туллаа. Хүнээ бодож, хувийн хэвшлээ дэмжих үү, улс төрөө бодож УИХ-ын сонгуулиа хийх үү.

Хэдийгээр Монгол Улс дотооддоо коронавирусийн халдвар бүртгэгдээгүй, гаднаас зөөвөрлөгдөн ирснийг эмчилсэн



Гэрэл зургийг С.Батсайхан

байдалтай байгаа ч энэ тахлын сүүдрээр Монголын эдийн засаг, хувийн хэвшил, жижиг дунд үйлдвэр эрхлэгчид хэдийн өвчилж, хатгаа болон хүндрээд байна.

Монголд 500 компани орон тооны цомхтгол хийх хэмжээнд хүрч, 260 мянган ажлын байр эрсдэлд орлоо. Угаасаа хоёр их наядын алдагдалтай болсон

ӨНӨӨДӨР МАРГАЛДАЖ ЦЭЦЭРХЭХ ЦАГ БИШ. ХЯМРАЛААС ХЭН Ч ЯЛАХГҮЙ. ХАРИН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХЭЛСЭНЧЛЭН НЭГДЭЖ БАЙЖ ТЭСЭЖ ҮЛДЭХ ҮЕ.

төсөв мөн хэмжээний хөрөнгөөр тасарч мэдэх эрсдэл давхар бүрдлээ.

Ийм том хямрал ирээд хаалга тогшиж байхад манай улс төрийн намууд ямар ч тооцоо судалгаагүй атлаа сонгуулийн том том мөнгөн амлалт өгч байгаа нь оргүй худлаас гадна тэд цаг үеэ огт мэдрэхээ байсны шинж. Харин Ерөнхийлөгч энэ

задгайралд цэг тавьж, нэгдсэн зохион байгуулалтаар хямралыг давж гаръя гэж хэллээ.

Тэрбээр зургаан зүйл бүхий уриалга гаргасан нь цагаа олсон алхам боллоо. Тэрбээр уриалгадаа төсвийг тодотгож, сонгуульд зориулсан болон тэвчиж болох бүх зардлыг танаж, үүнээс гарсан мөнгийг хямралын эсрэг арга хэмжээнд зарцуулахыг тусгалаа. Мөн УИХ-ын сонгуулийг хойшлуулж, түүнд зарцуулах хөрөнгө мөнгийг хэмнэх, хямралын үед хамаг хүндрэл бэрхшээлийг үүрч гарах үйлдвэр, аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих “Хямралын эсрэг” тусгай сан бүрдүүлэх... зэрэг зөв бүхнийг уриалсан юм. Монголын нийгмийг нуруундаа үүрч, ажлын байр бий болгогч хувийн хэвшлийнхэнд яг л одоо хэрэгтэй байгаа тэр шийдвэрүүд. Тэд ашиг олж, өсөж дэвжих биш амьд тэсч үлдэх гэж хичээж байна.

Тиймдээ ч өнөөдөр маргалдаж цэцэрхэх цаг биш. Хямралаас хэн ч ялахгүй. Харин Ерөнхийлөгчийн хэлсэнчлэн нэгдэж байж тэсэж үлдэх үе.

Хямралын үед халууныг атгах чадвар хүн бүрт байдаггүй, харин Ерөнхийлөгчид бол байна. ■

БАЙР СУУРЬ

Ч.Өнөрбаяр: Сонгуулиас өмнө Засгийн газрын бүрэлдэхүүнийг шинэчлэх ёстой

П.Батбөх, ЗГМ сонин



25-наас эхлэн мөрдөгдөнө. Энэ нэмэлт өөрчлөлтөөр олон заалт хэрэгжиж эхлэх ёстой. Үүний нэг нь Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай юм. Өөрөөр хэлбэл, Ерөнхий сайд Засгийн газрын кабинетийн гишүүдээ УИХ-д танилцуулж, тангараг өргүүлнэ. Ингэхийн тулд Ерөнхий сайд Засгийн газрын шинэ бүрэлдэхүүнээ тавдугаар сарын 25-наас өмнө УИХ-д танилцуулах ёстой.

Одоогийн Засгийн газрын гишүүд одоо 100 хувь УИХ-ын гишүүдээс бүрдсэн “давхар дээлтэй” байгаа. Харин тавдугаар сарын 25-наас Ерөнхий сайдаас гадна дөрвөн гишүүн л давхар дээлтэй байж болно. Тэгэхээр хэнийгээ засагт авч үлдэх нь МАН-ын

дотоод асуудал. Хэрэв зөрчвөл Засгийн газрын шийдвэр, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ Үндсэн хуулийн бус болж, хууль зөрчнө. Тиймээс Үндсэн хуульд нийцүүлэхээс өөр аргагүй. Гэтэл МАН үүний бэлтгэл хангасан уу гэдэг нь эргэлзээ төрүүлж байна” гэсэн юм.

Тэрбээр сэтгүүлчдийн асуултад хариулт өгөв.

- Үндсэн хуульд өөрчлөлт оруулах аас өмнө байгуулсан Засгийн газарт энэ нэмэлт өөрчлөлт хамаарахгүй гэсэн тайлбар байж болох уу?

-Шинэ Үндсэн хуулийн дэглэм мөрдөгдөх хуучин Үндсэн хуулийн дагуу байгуулсан Засгийн газрыг өөрчлөхөөс аргагүй. Засгийн газрын бүтцийн өөрчлөлтийг

Харин тавдугаар сарын 25-наас Ерөнхий сайдаас гадна дөрвөн гишүүн л давхар дээлтэй байж болно.

батлах УИХ хэвийн ажиллаж байгаа нөхцөлд өөрчилж л таарна. Сонгууль ойртсон, мөнгө хэмнээ гэх мэт жижиг шалтаг гарган Үндсэн хуулийн дээгүүр давж алхаж таарахгүй. Нөгөөтэйгүүр, шинээр томилогдох сайд нар УИХ-д тангараг өргөөд ажилдаа орчих гэж байна. Энэ нь зүгээр л ёслолын хээнцэрлэсэн үйл

ажиллагаа болох гээд байна. Ерөнхий сайд ямар дөрвөн сайдаа УИХ-аас сонгох вэ, бодлогын яамаа “давхар дээлтэй” хүнээр удирдуулах уу, чиглэлийн яамаар алийг нь сонгох вэ гэдгээ ил болгоод олон нийтээс санал авах ёстой.

-Эрх баригчид Засгийн газрыг нэг мөсөн сонгуулийн дараа байгуулахаар санал нэгдсэн юм биш үү?

-Тийм боломж байхгүй. Үндсэн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг баталсан. Түүгээр улс төрийн намыг байгуулах, Дархан, Эрдэнэтийг хот болгохтой холбоотой заалтуудыг л хойшлуулсан. Харин Засгийн газрыг байгуулах заалтыг бусад заалттай цуг хэрэгжүүлж эхлэхээр тусгасан. ■



Цахим мөрийтэй тоглоомын 20 гаруй серверийг шалгаж эхэллээ

Иргэдийн онлайн покерт алдсан мөнгө 10 тэрбумаар тогтохгүй, цаашид нэмэгдэх хандлагатай байна

Д.Хулан, ЗГМ сонин

Өнгөрсөн оны 11 дүгээр сард Монголд орогносон 800 хятадыг илрүүлж, өндөр хүчин чадалтай компьютер, гар утас, үндэсний үүрэн телефоны операторын 10 мянган дугаар зэргийг хурааж, нутаг буцаасан дуулиан гарч байв. Тэднийг онлайн мөрийтэй тоглоом эрхэлж, бусдаас их хэмжээний мөнгө залилсан, гэхдээ хохирогч нь монголчууд биш учраас хуулийн хариуцлага хүлээлгэхгүй улсад нь тушаасан гэдэг мэдээллээр энэ хачирхалтай шинэ үзэгдэл намжсан билээ.

Тэгвэл үүнтэй ижил цахим мөрийтэй тоглоом эрхэлдэг монгол иргэдийг тодорхой хугацаанд ажиглаж, гүйцэтгэх ажиллагаа явуулсны дүнд залилангийн гэмт хэргийн шинжтэйг тогтоож, баривчиллаа. “Ханан зууч” ХХК-ийг хамтран эзэмшигч Э.Баянхүү, Ж.Төгсжаргал нар 2017 онд интернэтийн худалдаа, компьютерийн үйлчилгээний эрх бүхий МК Soft ХХК-иа байгуулж, гаднын серверт түшиглэсэн апп, вебсайт хөгжүүлэн монголчуудыг онлайн покер буюу цахим мөрийтэй тоглоомтой танилцуулж байв. Хоёр жилийн хугацаанд иргэдээс нийт 10 гаруй тэрбум төгрөг компанийн болон хамаарал бүхий

этгээдүүдийн дансаар шилжүүлэн авсан нь тогтоогдсон байна. Бага мөнгөөр тоглож эхлэгсдийг донтуулан, өндөр дүнтэй тоглолт өрнөж эхлэхэд хаягийг нь блоклох, хөзрийг нь харж луйвардах зэргээр хохироодог байна. Сэжигтнүүд 2020 оны нэгдүгээр сард “Цахим покер сонирхогчдын холбоо” хэмээх нийтэд үйлчлэх төрийн бус байгууллага байгуулж, үйл ажиллагаагаа албажуулж эхлээд байв.

ХЭРЭГЛЭГЧГҮЙ ШИНЭ ОНЛАЙН ПОКЕР ПЛАТФОРМЫН ҮНЭ 1.5 САЯ ТӨГРӨГ БА САРЫН 400 МЯНГААР ТҮРЭЭСЭЛДЭГ ҮЙЛЧИЛГЭЭ ХҮРТЭЛ БИЙ БОЛЖЭЭ.

Харамсалтай нь, улсын бүтгэлээс хууль ёсны гэрчилгээг гардсан ч хууль бус үйлдлээ үргэлжлүүлэн хийсээр байжээ. Энэ хэрэгт холбогдуулан дээрх этгээдүүдийн харилцагчдыг шалгаж байгаа бөгөөд “Цахим покер сонирхогчдын холбоо”-ны хамтран эзэмшигч С.Батзоригийг мөн шалгах болсон аж.

Тэд луйвардсан мөнгөө “Ханан зууч” ХХК-ийн дансаар угааж,

300 гаруй сая төгрөгийн тансаг зэрэглэлийн зургаан орон сууц, Toyota Land cruiser, Lexus маркын автомашин тавыг худалдан авсан аж. “Ханан зууч” ХХК нь гадаад худалдаа, автомашин борлуулалт, барилгын засвар, бизнес зөвлөгөөний чиглэлээр үйл ажиллагааны зөвшөөрлөө авчээ.

Гэтэл энэ оны эхнээс цахимаар мөрийтэй тоглож, их хэмжээний мөнгөө алдсан гэх гомдол цагдаагийн байгууллагад хэд хэдэн удаа иржээ. Монголд онлайн покер тоглуулдаг 20 гаруй вебсайт, апп ажиллаж байна. Коронавирусийн халдвараас үүдсэн хөл хорионы үед хэрэглэгчдийн тоо эрс өссөн бөгөөд ихэнх нь 18-45 насныхан ажээ. Мөн онлайн покер платформ хийж зардаг этгээдүүдийг ч хамруулан шалгаж байна. Хэрэглэгчгүй шинэ платформын үнэ 1.5 сая төгрөг ба сарын 400 мянгаар түрээсэлдэг үйлчилгээ хүртэл бий болжээ.

Өнөөдөр Монголд мөрийтэй тоглоом хориотой бөгөөд цахим орчинд тоглох үзэгдлийг зохицуулсан хууль байхгүй. Одоо мөрдөгдөж буй Цахим тоглоомын үйл ажиллагааг зохицуулах журамд орон сууцны нэг давхарт үйл ажиллагаа явуулах, мөрийтэй болон терроризм, аллага, хүчирхийлэл, садар самуун сурталчилсан тоглоом тоглуулах, бичиг баримт, эд зүйл барьцаалан иргэдэд үйлчлэх зэргийг хориглодог. ■

Хятадын Худалдааг дэмжих хорооноос 1 сая амны хаалт, 2000 оношлуур “гуйв”


Коронавирусийн эсрэг тэмцэх бүхий л үйл ажиллагааг Улсын онцгой комисс хариуцан гүйцэтгэж байгаа. Гэхдээ төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд тус бүртээ эрвийх дэрвийхээрээ ажиллаж, гадаад, дотоод харилцаандаа түшиглэн нэмэр болохыг эрмэлзэж байна. Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимаас БНХАУ-ын Худалдааг дэмжих хороонд албан бичиг явуулж,

эрүүл мэндийг хамгаалах ажилд дэмжлэг хүсжээ. Ингэхдээ нэг сая амны хаалт, 2000 ширхэг оношлуурыг үнэ төлбөргүй нийлүүлэх хүсэлт илгээсэн байна. Хятадын Худалдааг дэмжих хороо хамтын ажиллагааны хүрээнд МХАҮТ-д ямар тусламж үзүүлж болох асуудалд санал ирүүлэхийг хүссэний хариуд ийнхүү нэн шаардлагатай байгаа хамгаалах хэрэгсэл, оношлуур хэрэгтэй буйгаа “дуулгажээ”. ■

Дуучин Ану өлсгөлөнгөөс аварна

“Хөөрхөн дэлхий” ТББ-аараа дамжуулан хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулдаг дуучин Ану буюу Ч.Уранхолбоо Ерөнхий сайдад хандаж уриалга гаргажээ. Тэрбээр “Хүнс ба дархлаа” хөтөлбөрийг яаралтай хэрэгжүүлж, хөл хорионы үед бага орлоготой, эмзэг бүлгийн хүүхэд, ахмад настнуудад тусламж үзүүлэх ажлыг яаралтай хэрэгжүүлэхийг хүсжээ. Хүнсний хэрэглээ нь хомсдож, дархлаа нь унас-

тэдгээр иргэдэд тусламжийн гараа сунгах сайхан сэтгэлт хүмүүсийг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, эрчимтэй ажиллуулахад өөрийн биеэр зүтгэхээ илэрхийлээд байна. ■



Уяачид 120 сая төгрөг, мянган хонь хандивлалаа

Монголын морин спорт, уяачдын холбооноос энэ сарын 6-25-ны өдөр эрүүл мэндийн үйл ажиллагааг дэмжихээр орон даяар “Морьтны хийморь” аян зохион байгуулжээ. Хөдөөгийн малчид, уяачид хорь хоногийн дотор 120 сая төгрөг хандивлаж, Ерөнхийлөгчийн урд хөршид

амласан 30 мянган хонины бэлгэнд нэмэр болгож мянган хонь мөн өгчээ. Монголын спортын холбоодоос хамгийн чинээлэг гишүүдтэйгээрээ ялгардаг уяачдыг зохион байгуулж, хандив цуглуулсан Ц.Батсайхан болон удирдлагуудад Эрүүл мэндийн сайд талархсан байна. ■

✎ О.Даваасүрэн, ЗГМ сонин

Элэгний В, С вирус гэх мэт элдэв халдвар тархах эрсдэлтэй газруудын нэг нь шүдний эмнэлэг.

Хэдийгээр энэ асуудал олон жилийн турш яригдаж, багаж, тоног төхөөрөмжөө ариутгаж хэрэглэхийг мэргэжлийн байгууллага шаарддаг ч хэрэгжилт хангалтгүй байна. Хяналт шалгалт, шалгуур, стандартад ч учир дутагдалтай зүйл олон бий. Энэ асуудлыг хөндөхөөр нийслэлд үйл ажиллагаа явуулж буй хэд, хэдэн шүдний эмнэлгээр орж, нөхцөл байдалтай танилцлаа. Гэтэл ариун цэврийн болон эрүүл ахуйн шаардлага хангахгүй эмнэлэг цөөнгүй байв. Хан-Уул дүүргийн I хороонд байрлаж буй нэгэн эмнэлэг хүүхэд болон насанд хүрэгчдэд үйлчилдэг бөгөөд үйл ажиллагаагаа явуулж эхлээд дөрвөн жил болж байгаа аж. Гэтэл ариун цэврийн өрөө, эмчилгээний танхимаас өөр талбайгүй, жижиг байранд байх агаад багаж ариутгах тусгай өрөөгүйгээ хэлж байлаа. Мөн Хүнсний нэгдүгээр дэлгүүрийн хажууд буй хоёр давхар байшинд үйлчилгээ эрхэлж байгаа эмнэлгийн нөхцөл байдал дээрхээс илүүрхэх зүйлгүй харагдсан. Үйлчлүүлэгчийн нүдээр харж, ажиглахад ч стандарт хангахгүй ийм эмнэлэг нийслэлд олон бий. Манай улсын шүдний эмнэлгийн эрүүл ахуйн стандартад мэсийн болон ариутгалын өрөө тусдаа байх, ариутгал халдваргүйжүүлэлт тогтмол хийх, барилгын талбай том байх зэрэг олон шалгуур байдаг ч шаардлага биелүүлэх үүрэгтэй иргэн, аж ахуйн нэгж болон хяналт тавьдаг хүмүүс хангалтгүй ажиллаж байгааг дээрх жишээ баталж байна.

ШҮДНИЙ ЭМНЭЛГҮҮДИЙГ АНГИЛСАН ӨРӨӨНҮҮДТЭЙ БОЛГОЁ

Манай улсын шүдний эмнэлгүүдэд тавигдаж буй стандартад учир дутагдалтай зүйл олон байна. Өндөр хөгжилтэй орны эмнэлгүүд үйлчлүүлэгчээрээ асуумж бөглүүлж, дадал зуршил, хэрэглэдэг эм бэлдмэлийг нь лавлаж, шинжилгээний бичгээ үзүүлэхийг шаарддаг. Хэрэв өвчтөн ямар нэг халдвартай бол тусгай өрөөнд, тусдаа багажаар эмчилгээ хийдэг бөгөөд насны хувьд ч ангилж, өөр өөр танхимд эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг байна.



📷 Гэрэл зургийг С.Батсайхан

Шүдний эмнэлгийн стандартыг шинэчлэх шаардлагатай

Гадаадын улс орнууд шиг В, С вирустэй, вирусгүй, хүүхдийнх гэх мэт өрөөнүүдтэй болгоё

Ингэснээр эрүүл хүнд халдвар тархах эрсдэлийг бууруулдаг аж. Энэ талаар Япон улсад суралцаж буй нэрээ нууцлахыг хүссэн иргэн “Би Японд ирснээсээ хойш нэг л удаа шүдний эмнэлэгт үзүүлсэн. Үнэхээр хариуцлагатай юм билээ. Надад асуумж өгч, бөглүүлсэн. Архи, тамхи хэрэглэдэг эсэх, харшилдаг зүйл болон халдварын вирустэй үгүйг маань шалгасан.

Эмч нар нь битүү хамгаалалтын хувцас өмсөөд, нэг удаагийн багажаар эмчилгээ хийдэг. Шинэ багаж хэрэглэж буйгаа болон хэрэглэсэн зүйлээ хаяж байгаагаа хэлдэг. Хувцас солиулж, нэг удаагийн малгай ч өмсүүлсэн. Том хүний эмчилгээний өрөөнд хүүхдийн шүд үздэггүй нь их таалагдсан. Монголд шүд аваад, зөвлөгөө өгөөд л явуулдаг бол энд хоёроос дээш удаа үзлэг, цэвэрлэгээ хийдэг” гэлээ. АНУ-д ч мөн энэ зарчмаар үйлчилгээ үзүүлдэг аж. АНУ-ын Сиэтл хотод оршин суугч А.Гэгээ “Энд шүдний эмнэлгийн тариф өндөр байдаг. Тиймээс чанар, стандарт сайтай. Хүүхдийн эмнэлэг насанд хүрэгчдэд үйлчилдэггүй.

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ӨГСӨН МЭДЭЭЛЛЭЭР УЛСЫН ХЭМЖЭЭНД ХАМГИЙН СҮҮЛД 2018 ОНД НЭГДСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН БАЙНА. ХАРИН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР УЛИРАЛ ТУТАМД ШАЛГАДАГ ГЭВ. ГЭТЭЛ ЭРҮҮЛ АХУЙН СТАНДАРТ ХАНГАХГҮЙ ЭМНЭЛГҮҮД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ, БУСДЫН ЭРҮҮЛ МЭНДЭЭР БИЗНЕС ХИЙСЭЭР БАЙГАА ЗӨРЧЛИЙГ ОЛЖ ИЛРҮҮЛЭХГҮЙ БАЙГААД ХЭН ХҮНИЙ ГАЙХАШ ТӨРМӨӨР.

Мөн хүмүүсийг В, С вирусийн халдвартай эсэхээр нь ангилж эмчилдэг” гэв.

Харин манай улсад вирустэй эсэхийг нь шалгаж, ангилдаг эмнэлэг тун цөөхөн. Халдварын вирустэй хүний тасаг хувь, хувьсгалын аль ч эмнэлэгт байдаггүй гэхэд хилсдэхгүй. Зарим хувийн эмнэлэгт элэгний вирусийн шинжилгээ тестээр авдаг ч хэрэв үйлчлүүлэгч халдвартай байвал ангилах өрөөгүй учир эмчилгээ хийдэггүй аж. Энэ нь шүдний эмнэлгээр халдвар тархах эрсдэл бий болгосоор байна. Тиймээс стандартыг шинэчилж, халдвартай болон эрүүл хүний тусгай тасгууд нээх нь олон эрсдэлээс сэргийлэх юм.

ХАМГИЙН СҮҮЛД 2018 ОНД ШҮДНИЙ ЭМНЭЛГҮҮДЭД НЭГДСЭН ШАЛГАЛТ ХИЙЖЭЭ

Улсын хэмжээнд 400 гаруй шүдний эмнэлэг үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр эмнэлэг эрүүл ахуйн стандарт мөрддөг эсэхийг болон ажлын

нөхцөл байдлыг нь шалгахад мэргэжилтэн хүрэлцдэггүй аж. Нийслэлийн эрүүл мэндийн төвийн өгсөн мэдээллээр улсын хэмжээнд хамгийн сүүлд 2018 онд нэгдсэн хяналт шалгалт хийсэн байна.

Харин мэргэжлийн хяналтын газар улирал тутамд шалгадаг гэв. Гэтэл эрүүл ахуйн стандарт хангахгүй эмнэлгүүд үйл ажиллагаа явуулж, бусдын эрүүл мэндээр бизнес хийсээр байгаа зөрчлийг олж илрүүлэхгүй байгаа хэн хүний гайхаш төрмөөр. Хоёр жилийн өмнө л нэгдсэн шалгалт хийсэн гэхээр шүдний эмнэлгүүд ямар түвшинд үйлчилдэг нь ойлгомжтой. 2018 оноос хойш өнөөг хүртэл яагаад шалгалт хийгээгүйг лавлахад тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулдаггүй учир бид жил бүр шалгах боломжгүй” гэх ойлгомжгүй тайлбар өгөв. Үнэхээр л шалгуулах эмнэлэг олон, шалгах мэргэжилтэн цөөн байдаг бол ядаж тусгай зөвшөөрөл олгохдоо хариуцлагатай хандах хэрэгтэй байна. ■

[ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН
Ерөнхий эрхлэгч
Баатарын Дуламхорлоо
Зөвлөх
Шатарбалын Даваадорж
Орлогч эрхлэгч
Лхагважавын Сугармаа
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Энхжаргал
Утас: 99901621

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба
Эдитор Б.Баяртогтох
Утас: 99901532

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581
99903578
99907843

ЦАХИМ ХУВИЛБАР

zgm.mn
ubinfo.mn

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
“Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ДУГААРЫН УДИРДАГЧ

Л.Сугармаа

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА
Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжлалтай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал
✉ **INFO@ZASAG.CO**
Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

Шинжилгээний хариу эерэг гарвал авчрахгүй

Ирэх сарын 2-4-ний өдөр нийт 750 иргэнийг эх оронд нь авчирч, 21 хоног тусгаарлана

Г.Санжааханд, ЗГМ сонин

Улсын онцгой комиссын шуурхай штабаас гадаадад байгаа иргэдээ хэрхэн авчрах талаар мэдээлэл хийлээ. Гадаадад буй 4805 иргэн Монгол Улсад ирэх хүсэлтээ Элчин сайдын яам болон дипломат төлөөлөгчдийн газраар дамжуулан мэдэгдсэн байна. Эдгээр тоо цаашид нэмэгдэх хандлагатай учраас ойрын хугацаанд тусгай үүргийн гурван онгоц нисгэхээр төлөвлөж, хуваарь гаргасан аж.

Энэ талаар ОБЕГ-ын дарга Т.Бадрал “Эдгээр нислэгээр нийт 750 хүнийг авчирна. Эхний нислэг ирэх дөрөвдүгээр сарын 2-ны 08:00 цагт Сөүл, 3-ны 01:00 цагт Токио руу ниснэ. Мөн 4-ний 08:30 цагт Сөүл рүү дахин нисгэнэ. Сөүлээс 2000 гаруй иргэн эх орондоо ирэх хүсэлт гаргасан тул тусгай үүргийн онгоцыг хоёр удаа нисгэж байгаа юм. Энэхүү гурван нислэгээр ирсэн иргэдийг 21 хоног тусгаарлана. Мөн тухайн улсдаа шинэ коронавирусийн шинжилгээ өгөхийг шаардаж байгаа. Шинжилгээний хариуг үндэслэж онгоцонд суух зөвшөөрөл олгоно” гэв. Мөн тэрбээр “Шинжилгээ нь эерэг буюу коронавирусийн халдвартай гарсан тохиолдолд Монголд авчралгүй тухайн улсад нь эмчилгээнд хамруулна. Харин хичээл, сургууль нь эхлэх гээд эх



Гэрэл зургийг Ж.Гэрэлчулуун

орноосоо явж байгаа хүмүүсийг хөл хорио цуцлагдтал эргүүлэн хүлээн авахгүй” хэмээв.

Тухайн нислэгээр ирэх иргэдийг хэрхэн бүртгэж байгаа талаар ГХЯ-ны Консулын газрын захирал Л.Мөнхтүшиг “Сөүлийн эхний онгоцонд бүртгүүлэхээр нийт 800 орчим хүн бичгээр хандсан. Тиймээс энэ удаад ирэх хоёр тусгай нислэгт эдгээр иргэдээс ирнэ. Шинжилгээг тухайн улсдаа хэрхэн өгөх талаар Элчин сайдын яамнаас чиглэл өгч, аюул эрсдэл

ТУСГАЙ ҮҮРГИЙН НИСЛЭГЭЭР ИРЭХ ИРГЭД ТУХАЙН УЛСДАА ШИНЭ КОРОНАВИРУСИЙН ШИНЖИЛГЭЭ ЗААВАЛ ӨГСӨН БАЙХ ЁСТОЙ. ШИНЖИЛГЭЭНИЙ ХАРИУГ ҮНДЭСЛЭЖ ОНГОЦОНД СУУХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОНО.

багатай зохион байгуулах талаар иргэдэд тухай бүрт нь мэдээлнэ” хэмээлээ.

Манай улс таван удаагийн нислэгээр гадаадад байгаа 9000 гаруй иргэнээ эх оронд нь авчраад буй. Нислэгийн үеэр зайлшгүй анхаарах шаардлагатай хэд хэдэн зүйл ажиглагдсан байна. Тиймээс энэ удаагийн нислэгүүдээр ирэх иргэдэд МХЕГ-ын дэд дарга Г.Сугарбат дараах зүйлсийг анхааруулсан юм. Тэрбээр “Гурван удаагийн тусгай нислэгт

Мэргэжлийн хяналтын Эрүүл ахуй, халдвар хамгааллын улсын хоёр байцаагч дагалдан явж, онгоцны буудал дээр болон онгоцонд асуумж авна. Эдгээр байцаагч эмч мэргэжилтэй. Халдвар, хамгааллын дэглэмийг сахиулах тул иргэд тэдний зааврын дагуу тайван, хүлээцтэй байх хэрэгтэй.

Зорчигчдод өгөх асуумж нь эрүүл мэндийн 20 асуулттай ба үүнээс 14 төрлийн шинж тэмдгийг зорчигч заавал бичих ёстой. Үнэн зөв бичихгүй бол хуулийн дагуу хариуцлага хүлээлгэхээр сануулсан. Сүүлийн 14 хоногт явсан газрууд болон хаагуур дамжиж ирж байгаагаа заавал дэлгэрэнгүй бичнэ. Мөн онгоцонд аль болох шилжилт хөдөлгөөн хийхгүй, суудалдаа сууж, амны хаалтаа зүүх ёстой. Онгоцонд суухад амны хаалт тарааж өгнө. Тодорхой хугацааны дараа амны хаалтаа солино. Сольсон маскаа хаа хамаагүй хаяхгүй. Онгоцны үйлчлэгч тусгай саванд авна.

Халуун бууруулах эм хэрэглэх шаардлагагүй. Эрсдэлтэй байгаагаа эртхэн мэдэгдсэнээр тусгаарлах байр руу явж, эмчлүүлэх ба энэ нь эрүүл мэндээ хамгаалж буй хэрэг. Энгийн нислэг биш учраас онгоц газардахад бүх хүн босож, үймж болохгүй. Бүх хүнийг нэрээр нь дуудах тул заасан хаалгаар гарна. Ингэснээр тухайн иргэнийг тусгаарлан эмчлүүлэх үү, тусгаарлан ажиглуулах уу гэдгийг шийднэ” хэмээн анхаарууллаа. ■

мэдээ, мэдээлэл

COVID-19-ийн тохиолдол 11 болж бүртгэгдлээ

Энэ сарын 18-ны өдөр **Истанбул-Улаанбаатар чиглэлийн тусгай үүргийн онгоцоор ирсэн нэг иргэн COVID-19-ийн халдвар авсан болохыг шинжилгээгээр тогтоожээ.** Энэ талаар ХӨСҮТ-ийн ерөнхий захирал Д.Нямхүү “Истанбул-Улаанбаатар чиглэлийн нислэгээр ирсэн 221 хүнд шинжилгээ хийж дууслаа. Үүний дотроос нэг иргэн шинэ коронавирусийн халдвар авсан болохыг тогтоосон. Мөн тандалтын зорилгоор цуглуулсан 25 сорьцод

коронавирус илрээгүй. Нэг сэжигтэй тохиолдол пүрэв гарагт ХӨСҮТ-д ирсэн бөгөөд нийт 184 хүн хяналтад байна. Тусгай үүргийн онгоцоор ирсэн хүмүүсийг бид байнга хянаж байгаа” гэв.

Тухайн хүний ойрын хавьтлыг тодорхойлох зорилгоор онгоцонд суусан суудлын дугаарыг нь нягталж үзэхэд буруу бөглөсөн байжээ. Тиймээс сэжигтэй тохиолдлуудыг илрүүлэхэд хүндрэл учирч байгааг МХЕГ-ын дэд дарга Г.Сугарбат хэллээ. ■

Угаар мэдрэгчийн заавартай танилцахыг зөвлөв

Өнгөрсөн гурав хоногт зургаан өрхийн 11 иргэн угаарын хийд хөнгөн хэлбэрээр хорджээ. Иргэд угаарын хий мэдрэгчийг унтрааснаас болж угаартах тохиолдол цөөнгүй бүртгэгдэж байгаа аж. НМХГ-ын Агаарын чанарын хэлтсийн дарга Н.Шинэ-Оргил “Хавар, намрын улиралд угаартах эрсдэл их байдаг тул иргэд галлагаагаа зөв хийж, угаарын хий мэдрэгчээ унтрааж болохгүй. Угаар мэдрэгчийг иргэдэд тараахдаа гарын авлагын

хамт өгсөн. Нэгдүгээрт, гарын авлагаа унших хэрэгтэй. Хоёрдугаарт, угаарын хий мэдрэгчийн дохиолол дуугарсан тохиолдолд гэрт агаар оруулах ёстой.

Иргэд угаарын хийг агаар сэлгэлтээр бүрэн гаргасны дараа тухайн дохиолол өөрөө унтарна. Түүнээс биш дохиолол асангуут иргэд унтраах гэж оролдож болохгүй. Учир нь гэрт угаар байгаа учраас дуугарч байна гэдгийг иргэд ойлгох хэрэгтэй” хэмээв. ■

ЗГМ: ТОВЧХОН

■ БОРЛУУЛАЛТ

Сайжруулсан шахмал түлшийг энэ зун томоохон авто зам дагуух борлуулалтын цэгүүдээр худалдаална.

■ БУЦААН ОЛГОЛТ

НӨАТ-ын буцаан олголтын нэгдүгээр улирлынхыг ирэх сард олгоно.


■ ОРОН НУТАГ

Одоогийн байдлаар нийт нутгийн 20 хувь нь цастай байгаагаас Завхан, Увс, Хөвсгөл, Архангай аймагт хаваржилт хүндрэх төлөвтэй байна.

[ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИН]

**ХЭР ИХИЙГ УНШИХ НЬ БУС
ЮУГ СОНГОЖ УНШИХ НЬ ЧУХАЛ**

#ReadSmart #ReadResponsibly #ReadZGM



**ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА
ЯГ ОДОО ЗАХИАЛ**

ТА ЕРДӨӨ ЗАЛГАХАД ХАНГАЛТТАЙ

Утас: 7010 3131

www.zgm.mn



Та мобайл банкны аппликейшнаараа QR кодыг уншуулан гүйлгээний утга хэсэгт **и-мэйл хаяг, утасны дугаараа** бүртгүүлж, “Засгийн газрын мэдээ” сониныг захиалаарай.

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Монголдоо ирээд тусгаарлагдсан иргэдэд хэлэх хэдэн үг

Халдварын нэг л тохиолдол нийгэмд тархвал яаж өвсөнд ассан түймэр шиг газар авдгийг Итали, Франц, Америк, БНСУ гэх мэт их гүрнүүдийн гашуун сургамж бэлхнээ харуулж байна

✍ Б.Энхжаргал, ЗГМ сонин

Дэлхий нийтийг нөмрөөд буй цар тахалтай холбоотой таагүй мэдээллийг өдөр бүр авсаар, “Өнөөдөр хаана, хэдэн хүн коронавирусээр нас барсан байна” гэж асуух хэмжээнд хүрсэн нь эмгэнэлтэй.

Сүүлийн хэдэн долоо хоногт дэлхийн хамгийн хүчирхэг, хөгжингүй орнууд коронавирусийн өмнө өвдөг сөхөрч, цөхрөнгөө барж байгааг харахад өвчин тахал нэг дэгдэхээрээ хэнбэгуайг ч үл ялгаж, юу ч зогсоож дийлдэггүй болохыг илтгэнэ. **Ердөө гурван сарын хугацаанд дэлхийн 192 оронд энэ халдвар тархаж, 462 мянган хүн халдварлаж, 20,000 гаруй хүний амийг авч одсон байна.**

Харин Монгол Улсад коронавирусээр халдварласан шинэ тохиолдол нэгээр нэмэгдсэн муу мэдээг өчигдөр ХӨСҮТ-ийн ерөнхий захирал Д.Нямхүү дуулгаж, нийт 11 хүн энэ вирусээр өвдсөнийг баталлаа. Тухайн иргэн тусгаарлалтад байсан гэдгээрээ нэг талаар тайвшруулж байгаа ч нөгөөтэйгүүр **Монголд ирснээс хойш найм хоногийн дараа халдвартай нь батлагдаж байгаа нь айдас төрүүлж байна.**

Ийм олон хоног нууц үед байсан вирус энэ хооронд хэдэн хүнд халдварлах боломжтойг бодохоос ч зүрхшээмээр. Тэр дундаа гадаадаас тусгай үүргийн нислэг болон бусад хилийн боомтоор Монголдоо ирж тусгаарлагдсан иргэний тоо 3000 хол давж, хүн нэг бүрийг тусад нь байлгах боломж байгаагүй. **Сэжигтэй тохиолдол эртдээ найм хоногийн дараа вирусээр халдварласан нь батлагдаж байхад эмнэлэг болон тусгаарлах, ажиглах байр, хавьтлууд бүгд хэзээ ч тэсэрч мэдэх “галт бөмбөг” юм биш үү.**

ДЭМБ-ын мэргэжилтний хэлж буйгаар нэг хүн дараагийн хүнийг халдварлуулах хугацаа 4.8 хоног аж. Харин өвчний нууц үе дунджаар зургаа хоног, шинж тэмдэг илрээд эмнэлгийн тусламж авах хугацаа гурав хоног бол, шинжилгээний хариу

гарч, хавьтлыг тусгаарлах хүртэл ойролцоогоор 18 хоног байна. Өөрөөр хэлбэл, ердөө гурван тохиолдлын судалгааг хийж байхад цаанаа 36 болж нэмэгдэх аюул дагаж байна гэсэн үг.

Гэхдээ улс юм хойно эх орондоо харих хүсэлтэй иргэдээ хариас авчирч л таарна. Төр, засаг нь улс орноо батлан хамгаалах үүрэгтэй. Батлан хамгаалах тэрхүү “улс орон” гэдэгт иргэдийнх нь амь нас, аюулгүй байдал ч багтдаг тул гадаадаас иргэдээ тусгай үүргээр авчирч буй, цаашид ч авч ирэхээр төлөвлөж /Япон, БНСУ-аас/ байгааг нь буруутгах аргагүй. **Харин**

өчигдөр гаргалаа. Мөн ирэх сарын эхнээс тусгай үүргийн онгоцоор ирэх хүн нэг бүрийг тусдаа байрлуулах болсон нь нэгээс нөгөөд халдварлах эрсдэлийг тооцсон алхам биз.

Харин энэ өвчнөөс урьдчилан сэргийлэхэд бүх хүчээ шавхаж, өдөр шөнөгүй ажиллаж буй эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд, эмч сувилагчид, бусад төрийн байгууллагын албан хаагчдын өмнөөс **гадаадаас ирж буй иргэдэд илгээх хэдэн үг байна.**

Монголд болон шинээр бүртгэгдэж буй бусад оронд ч вирусийн халдвар зөөвөрлөгдөн очиж буй. Өөрөөр хэлбэл халдвартай улс оронд зорчсон иргэд вирус тээн харьж байна. Яг үүнтэй холбоотой Монголын нийгэм өнөөдөр хоёр хуваагдчихаад байгаа. “Гурван сая хүнээ бодсонгүй, гадаадаас иргэдийг авчирч вирус импортоллоо” гэж шүүмжлэх нэгэн байхад “Харийн нутагт элэг нэгтнээ хаяж яаж болох вэ” гэж өмөөрөх нь ч бий. Аль аль нь үнэний ортой. Харин бодит үнэн гэвэл Монгол Улс гадаадад байгаа



авчирсан хойноо халдвар хамгааллын аюулгүй байдлаа чанд сахиж, халдваргүй гэдэг нь бүрэн дүүрэн батлагдсаны дараа тусгаарлалтаас гаргах нь л чухал болоод байна. Тэр дундаа дэлхийн шилдэг эрдэмтэд вирус мутацлагдаж, 14 биш 21 хоног ч нууц байх чадвартайг нь зарлаж буй энэ үед тусгаарлалт л гол хамгаалалт болно.

Тиймээс манай орон **гадаадаас ирж буй иргэдийг 21 хоног тусгаарлах шийдвэрийг**



иргэдийг авах, тусгаарлах, шинжилгээ оношилгоо хийхэд маш их хөрөнгө зарцуулж буй. Хүн хүчний тухайд ярих ч юм биш. Унтах нойр, идэх хоолоо хойш тавьж, халаа чөлөөгүй ажиллаж буй эмнэлгийн ажилтнууд, онцгойгийнхон, хил гаалийнхан, цэрэг, цагдаа нар хэний төлөө энэ их үүргийг хүлээж буй гэж бодож байна. Халдварын нэг л тохиолдол нийгэмд тархвал яаж өвсөнд ассан түймэр шиг газар авдгийг Итали, Франц, Америк, БНСУ гэх мэт их гүрнүүдийн гашуун сургамж бэлхнээ харууллаа.

Тэдгээр орны заримд нь өдөрт бараг 700 хүн энэ тахлаар нас барж, эмнэлгийн ажилтнууд нь төр засгийнхаа эсрэг бослого гаргаад эхэлчихэв.

Харин аз болоход Монгол Улс одоогоор аймшигт тахлын халдварыг нийгэм рүүгээ алдаагүй байна. **Тиймээс гадаад**

орноос тэр дундаа халдварын голомтоос эх орноо зорьж ирсэн, ирэхээр зэхэж буй иргэн та ухамсартай байж, вирусээс урьдчилан сэргийлэх төрийн ажилд хүндэтгэлтэй хандана уу. Байрыг нь голж гэнэ, хоолыг нь шидэж гэнэ, эмнэлгийн ажилтнуудтай хүндэтгэлгүй харьцаж, тавьсан шаардлагыг нь биелүүлэхгүй, дүрэм журам сахихгүй, тусгаарлах байранд байрласан мөнгөө төлөхгүй байгаа талаар мэдээлэл их сонсогдож байна.

Иргэд минь ээ, эх орноо гээд ирсэн монголчууд аа. Хэрэв та нар хүний нутагт байсан бол яах вэ. Харь оронд тэр чигээрээ хаягдсан бол хэрхэх вэ. Хэн та нарыг хооллож, орон байраар хангаж, эмчилж сувилах юм бэ. Энэ өвчнийг Монголд тараах эрсдэлт бүлгийнхэн та нар. Та бүхнийг тусгаарлаж байгаа нь гурван сая иргэнээ хамгаалж буй хэрэг. Тэр гурван сая иргэний дунд таны ч ээж аав, үр хүүхэд, хань ижил, ах дүү, хамаатан садан бий. Бид цөөхүүлээ шүү дээ. Дүрэм журмыг сахь, эмч нарыг ойлго, төрөө хүндэл. Бас төлбөрөө төл. ■

ЭДИЙН ЗАСАГ

⊖ Ажлын байрыг хадгалж үлдэхийг улс орнууд урьтал болгож байна → 9

⊖ А.Билгүүн: Урт хугацаандаа зэсийн үнэ буурч магадгүй → 10

⊖ Улс орнууд цар тахлын эсрэг арга хэмжээ авахдаа хугацаа алдаж байна → 11

⊖ Нью-Йоркт нохой, муурны хомсдол нүүрлэв → 11

ЗГМ: ТОВЧХОН

■ АРИЛЖАА

29

Компани. Монголын хөрөнгийн бирж пүрэв гарагийн үнэт цаасны арилжаагаар 32 компанийн 2,594,869 ширхэг хувьцаа арилжлаа. Энэ өдөр 10 компанийн хувьцааны ханш өсөж, 17 компанийнх буурав.

■ ИНДЕКС

1.46

Хувь. ТОП 20 индекс 1.46 хувиар буурч, зах зээлийн үнэлгээ 2.5 их наяд төгрөг боллоо.

■ ЭКСПОРТ

19

Хувь. БНХАУ-ын коксжих нүүрсний импортын 19 хувийг энэ оны эхний хоёр сард Монголын нийлүүлэлт бүрдүүлсэн байна. Үүнээс өмнө 2019 оны 12 дугаар сард БНХАУ-ын коксжих нүүрсний импортын 92.3 хувийг Монгол Улс хангаж байжээ.

■ УУЛ УУРХАЙ

2.5

Хувь. 2020 онд нүүрс, зэс, газрын тосны экспорт огцом буурсан бол эдгээрээс бусад эрдэс бүтээгдэхүүний экспортод томоохон өөрчлөлт гараагүй бөгөөд хэвийн үргэлжилж байна. Оны эхнээс хойш энэ сарын 23 хүртэлх хугацаанд 1.88 сая тонн төмрийн хүдэр экспортолсон нь жилийн өмнөхтэй харьцуулахад 2.5 хувиар өсжээ.

■ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Дэлхийд зэс олборлолтоор тэргүүлэгч Codelco компани COVID 19 вирусийн тархалтаас үүдэн Чили дэх зарим төслүүдээ 15 хоногийн турш түр зогсоохоо мэдэгдлээ.

■ ХЭРЭГЛЭЭ

78.8

Сая. Дэлхийн хэмжээнд автомашины борлуулалт энэ онд огцом буурах төлөвтэй байгааг IHS Markit-ийн судалгаа харууллаа. Судалгаагаар автомашин үйлдвэрлэгчдийн нийлүүлэлт 12 гаруй хувиар буюу 78.8 сая нэгжээр буурна гэсэн тооцоо гарсан байна.



Гэрэл зургийг Ж.Гэрэлчулуун

Монголын хөрөнгийн зах зээлийг COVID-19 чичиргэж эхэллээ

ТОП-20 индекс сүүлийн найман өдөр дараалан буурч, 2017 оны есөн сараас хойших хамгийн доод түвшинд хүрээд байна

✎ Б.Мөнх-Эрдэнэ, ЗГМ сонин

Дэлхийн хөрөнгийн зах зээлийн түүхэнд “хар өдрүүд” өнгөрч байна. Эдийн засагт сүүлийн хэдэн арван жилд үзэгдээгүй хүндхэн цохилт авчирсан COVID-19 вирусийн нөлөө улс орнуудыг тэвдүүлсээр. Улаанаараа эргэсэн Америкийн зах зээл дөнгөж сэхэл авч байна. Хэдий тийм боловч уналт үргэлжилсээр. Хөрөнгийн зах зээл хамгийн мэдрэмтгий байдаг. Энэ утгаараа хөрөнгө оруулагчдын үйл хөдлөл уг зах зээлийг доргиож, хувьцааны үнэ огцом хэлбэлзэж байна. Олон улсын хөрөнгийн зах зээл дэх өөрчлөлт хямрал, боломжийг хөрөнгө оруулагчдад зэрэг санал болголоо. Манай улсын дотоодын хөрөнгийн зах зээл мөн адил сүүлийн хоёр өдөр хүчтэй савлалаа. Тухайлбал, лхагва гарагт ТОП-20 индекс 2.35 хувиар буурч, зах зээлийн үнэлгээ 2.5 их наяд төгрөг

болов.

Тус индекс сүүлийн найман өдөр дараалан буурч, 2017 оны есөн сараас хойших хамгийн доод түвшинд байна. COVID-19 вирусийн нөлөөгөөр аж ахуйн нэгжүүдийн 30 гаруй хувь нь ажилтнаа цомхотгож, зардлаа бууруулахаа мэдэгдсэн. МҮХАҮТ-ын судалгаагаар 260 гаруй мянган ажлын байр эдийн засгийн хүндрэлээс үүдэн эрсдэлд ороод буй. Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд ч эрсдэлийн гадна үлдэхгүй нь. Нийт 198 компани дотоодын хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй байгаагаас 2019 онд 78 нь ашигтай ажилласан бол 48 нь алдагдал хүлээсэн. Тэгвэл энэ оны хувьд үйл ажиллагаа явуулаагүй болон алдагдалтай ажиллах компанийн тоо эрс нэмэгдэж болзошгүй байна.

Тодруулбал, аялал жуулчлал, тээвэр, худалдаа, үйлчилгээ гээд бүхий л салбарт хямралын шинж хэдийн ажиглагдаж эхэлсэн билээ. Энэ онд 29 компани ногдол ашиг тараахаа

Тор 20 индекс (нэгжээр)



мэдээлсэн. Харин ирэх онд ногдол ашиг тараах компанийн тоо болон нэгж хувьцаанд ногдох үнэлгээ хумигдах магадлал улам нэмэгдсээр. Сайн үзүүлэлт гэвэл дотоодын хөрөнгийн зах зээлд онлайнаар арилжаанд оролцогчдын тоо эрчимтэй өсөж байна. Өнгөрсөн онд Монголын хөрөнгийн биржийн арилжаанд оролцож буй хөрөнгө оруулагчдын 32.5 хувь нь онлайнаар арилжаанд оролцож байсан. Тэгвэл энэ оны гуравдугаар сарын байдлаар нийт хөрөнгө оруулагчдын 49.2 хувь нь онлайнаар арилжаанд оролцжээ.

COVID-19 вирустэй холбогдуулан хөл хорио тогтоосноор иргэд биеэр бус онлайнаар арилжаанд оролцох хандлага цаашид өсөх шинжтэй. ОУВС-гийн удирдлага “Дэлхийн эдийн засаг ойрын саруудад багаар бодоход дэлхийн санхүүгийн

хямралын үе буюу түүнээс ч их хэмжээгээр унах болно” гэж анхааруулсан. Хувьцааны зах зээлд яарч сандарсан арилжаа олширч, MSCI дэлхийн индекс энэ он гарсаар 32 хувиар доошилжээ. Дэлхийн томоохон хөрөнгийн зах зээлтэй харьцуулахад манай дотоодын хөрөнгийн зах зээл “хөлдүү”. Хэдий тийм боловч эдийн засгийн уналт “хөлдүү” зах зээлийг хөдөлгөөнд оруулж байна.

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нийт компаниудыг үнэлгээгээрээ тэргүүлэх “АПУ” компанийн зах зээлийн үнэлгээ хоёр өдрийн өмнө 86 тэрбум төгрөгөөр буурч, 500 тэрбум төгрөгт хүрсэн бол “Говь” компанийн хувьцааны ханш 200 төгрөгөөр мөн уруудсан. “Говь” компани 2018 онд нэгж хувьцаагаа 100 хувааснаас хойш хамгийн доод ханшийн унасан үзүүлэлт энэ болов. Дэлхий нийтээр аялал жуулчлалын салбар хямралтай нүүр тулж, жуулчдад түшиглэсэн худалдаа эрс хумигдаж байна. “Говь” компанийн хувьд гаднын жуулчдаас олох орлогоо энэ онд алдах эрсдэл улам нэмэгдэж болзошгүй. Зах зээлийн тэргүүлэх индекс пүрэв гарагт мөн л үргэлжлэн уналаа. ТОП-20 энэ өдөр 1.12 хувиар буурч, зах зээлийн үнэлгээ 2.4 их наяд төгрөг боллоо. ■



АЖЛЫН БАЙРЫГ ХАДГАЛЖ ҮЛДЭХИЙГ УЛС ОРНУУД УРЬТАЛ БОЛГОЖ БАЙНА



Нэн шаардлагатай бус хөрөнгө оруулалтыг хойшлуулж, хувийн хэвшлийн алдагдлыг бага байлгах бүхий л арга замыг эрэлхийлэх болов.

Гэрэл зургийг С.Батсайхан

Б.Баяртогтох, ЗГМ сонин

Коронавирусийн цар тахлын үед дэлхийн улс орнууд эдийн засгийн хямралтай тэмцэхийн тулд ямар арга хэмжээ авч байгаа талаарх хоёр дахь цувралаа бид энэ удаа хүргэж байна. Уналт гүнзгийрэх нь улам тодорхой болж, зах зээлийн итгэл суларч эхэллээ. **Бизнесүүд хаагдсанаар ажилгүйдэл тэлж, энэ нь бодлого тодорхойлогчдын толгойн өвчин болж байна. Ажлын байрыг хамгаалах арга хэмжээ цаг алдалгүй авахаа улс орны эрх баригчид мэдэгдэж, дэлхийн санхүүгийн ертөнцөд юу болж байгааг дор бүрнээ ажигласаар. Их гүрнүүд мөнгөний зөөлөн бодлого руу хэлбийж, төсвийн зардлаа эргэн харж байна.**

Нэн шаардлагатай бус хөрөнгө оруулалтыг хойшлуулж, хувийн хэвшлийн алдагдлыг аль болох бага байлгах бүхий л арга замыг эрэлхийлэх болов. Тэдний нэг нь Франц улс. Тус улс эдийн засаг,

эрхүүдийг дэмжих зорилгоор 300 тэрбум еврогийн өртөгтэй хөтөлбөр хэрэгжүүлж байна. Иргэдийн амьжиргаа дордож эхэлсэн тул эрхүүдийг газ, цахилгаан, халаалт, түрээсийн төлбөрөөс чөлөөлж, 335 тэрбум ам.долларын банкны зээлд Засгийн газар нь баталгаа олгохоо мэдэгдлээ.

Европын орнууд хувийн хэвшлийн компанийн зээлд баталгаа гаргаж, эдийн засгийн уналтыг саармагжуулах тусгай хөтөлбөр хэрэгжүүлж байна. Тухайлбал, Испанийн Засгийн газар 100 тэрбум ам.долларын компанийн зээлд баталгаа өгч, 17 тэрбум еврогийн шууд дэмжлэг хувийн хэвшилдээ үзүүлэхээ илэрхийлсэн. COVID-19 вирусээс хамгийн их хохирол амсаж буй Итали улс 28 тэрбум ам.долларын төлөвлөгөө гаргаж, жижиг дунд бизнес эрхлэгчдэд зээл олгох баталгааны санд мөнгө нэмж оруулахаар боллоо.

Түүнчлэн Англи улс хувиараа хөдөлмөр эрхэлдэг болон ажилгүй хүмүүст зориулсан Засгийн газрын тэтгэмжийн хүртээмжээ өргөжүүлж, корпорацын бондуудыг 200 тэрбум ам.доллар болгон нэмэгдүүллээ. Азийн эдийн засагт нөлөө бүхий оролцоотой БНХАУ, БНСУ, Япон хямралтай хэрхэн тэмцэж байгааг бид эхний цувралдаа онцолсон. Эдгээр орон эдийн засгийн хямралаас өөрсдийгөө аврах ажиллагааг хамгийн ажил хэрэгчээр шийдвэрлэж буй.

Morgan Stanley банкны таамгаар АНУ-ын ДНБ энэ оны хоёрдугаар улиралд жилийн дүнгээр 30 хувь унаж, ажилгүйдлийн түвшин 12.8 хувьд хүрэх төлөвтэй байна. Тиймээс Холбооны нөөцийн сан 500 тэрбум ам.долларын үнэт цаас, 200 тэрбум ам.долларын орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаас худалдан авсан. Мөн бизнес, ажил эрхлэлтийг хамгаалах үүднээс нэмж хоёр их наяд ам.долларын санхүүгийн

дэмжлэг АНУ-ын Сенат олгохоор зарлалаа. Хойд хөрш болох ОХУ-ын төрийн тэргүүн В.Путин эдийн засгийн хямралаас хамгаалах, бизнес эрхлэгчдийг дэмжихээ мэдэгдлээ.

Үндсэн хуульд өөрчлөлт оруулах талаарх бүх нийтийн санал асуулгыг хойшлуулж байгаагаа хойд хөршийн тэргүүн үүгээр мэдэгдсэн. Бизнесийн хэвийн үйл ажиллагааг дэмжих үүднээс жижиг дунд бизнес эрхлэгчдийн татварыг зургаан сараар хойшлуулахаар болсон. Мөн хөрөнгийн гадагшлах урсгалыг хязгаарлахын тулд Оросоос гарч буй бүх хүү, ногдол ашгийн төлбөрийг одоогийн хоёр хувиас дээш 15 хувь болгох санал гаргав. Ажилгүйдлийн тэтгэмжийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй ойртуулахын тулд сард 152 ам.доллар болгон нэмэгдүүлэх санал мөн дэвшүүлээд байна. Хөл хорио тогтоосон хугацаанд иргэдийнхээ цалин болон бусад хангамжийг хэвээр хадгалахыг онцлон тэмдэглэсэн юм. ■

УУЛ УУРХАЙ

Steppe Gold хүдэр боловсруулах үйлдвэрлэлээ эхэллээ

Steppe Gold компани “Алтан цагаан овоо” ордын хүдэр боловсруулах үйлдвэрлэлээ эхэллээ. Тус компани тонн тутамдаа хоёр грамм алтны агуулгатай 533 мянган тонн хүдрийн чулуулгийг олборлож, овоолгон уусгах технологиор боловсруулж эхэлжээ. Алтны гарцын хувь нь 70 хувьтай байх тооцоотой. Одоогоор Steppe Gold компани ялган боловсруулах боломжтой 24 мянган унц алт бүрдээд байгаа юм. Нэг унц алтны ханш 1600 ам.доллар байна гэж тооцвол энэ нь 38 сая ам.долларын мөнгөн дүнтэй дүйцэж байна. Steppe Gold компани 2020 онд нийт 60 мянган унц алт үйлдвэрлэхээр төлөвлөжээ. “Алтан цагаан овоо” ордоос бүрдүүлсэн эерэг бэлэн мөнгөний урсгалаа цаашид ил уурхайгаа өргөжүүлэх судалгаа болон боловсруулах үйлдвэрлэлийн хүчин чадлаа өргөжүүлэхэд зориулахаар төлөвлөснөө тус компани мэдэгдлээ. “Бид Монголын санхүүгийн байгууллагууд болон хувь нийлүүлэгчдээсээ сайн дэмжлэг авч, хайгуул, хөгжүүлэлтээс олборлолт, үйлдвэрлэлийн шат руу шилжиж байгаадаа баяртай байна” гэж Steppe Gold-ийн гүйцэтгэх захирал Т.Батаа мэдэгджээ. ■

“МИАТ” ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ХОЁР ГИШҮҮН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР

Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, 81.2 дахь заалт, Төрийн өмчийн хорооны “Төрийн өмчийн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулж, томилох үлгэрчилсэн журам”-ын 2, 3 дугаар зүйлийг үндэслэн “МИАТ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус хоёр гишүүний сонгон шалгаруулалт зарлаж байна.

Нэг. Тавигдах шаардлага:

- 1.1. Маркетинг, Бизнесийн удирдлага, Эрх зүйч мэргэжилтэй, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх; /Нийгмийн даатгалын дэвтрээр баталгаажуулах/
- 1.2. сүүлийн 5 жилд “МИАТ” ТӨХК-д ажиллаж байгаагүй, одоо ажилладаггүй, мөн ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг, өрсөлдөгч аж ахуйн нэгжид ажиллаж байгаагүй, бизнесийн хэлхээ хамааралгүй байх;
- 1.3. компанитай нэгдмэл сонирхолтой болон үйл ажиллагаанд оролцогч талуудын /зээлдэгч, хувь нийлүүлэгчид, хөрөнгө оруулагч, хамтран ажиллагч г.м/ ашиг сонирхлыг төлөөлдөггүй байхаас гадна бизнесийн аливаа хамааралгүй байх;
- 1.4. төлөөлөн удирдах зөвлөлийн бусад, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдтэй нэгдмэл сонирхолтой этгээд биш, тэдэнтэй төрөл садангийн холбоогүй байх;
- 1.5. компанийн томоохон хэрэглэгчийн хяналтын багц эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан биш байх; / нэг жилд тухайн харилцагчтай хийсэн хэлцлийн нийт дүн нь компанийн нийт активын 10 хувиас дээш хувьтай тэнцэж байвал томоохон харилцагч гэж үзнэ/
- 1.6. нэр дэвшигч өөрөө, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд бие даан нэр дэвшүүлэх, нэр олгохуйц хувьцааны багц эзэмшдэггүй байх;
- 1.7. компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байх;
- 1.8. компанийн засаглалын сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх;

- 1.9. Компанийн засаглалын үйл ажиллагаанд төлөөлөл хэрэгжүүлэн ажиллаж байсан дадлага, туршлагатай бол давуу тал болно.

Хоёр. Сонгон шалгаруулалтад оролцохыг хязгаарлах нөхцөл:

- 2.1. тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг нь шүүхийн шийдвэрээр хассан, эрүүгийн хуульд заасан онц гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлсэн;
- 2.2. төрийн албан хаагч буюу тухайн салбарын төрийн өмчийн оролцоотой, эсхүл хувийн өмчийн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байх;

Гурав. Бүрдүүлэх материал:

- 3.1. сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт;
- 3.2. өөрийг нь сайн мэдэх, олонд танигдсан 2 хүний гаргасан ажил байдлын тодорхойлолт
- 3.3. анкет; /ТАХ-ийн анкет/
- 3.4. боловсролын диплом, үнэмлэх, гэрчилгээ;
- 3.5. иргэний үнэмлэх; /нотариатаар гэрчлүүлсэн/
- 3.6. цагдаагийн байгууллагын тодорхойлолт;
- 3.7. нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангасан гэдгээ баталсан нотолгоо
- 3.8. нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар;

Дөрөв. Сонгон шалгаруултын материалыг хүлээж авах хаяг:

Улаанбаатар хот, Буянт-Ухаа, “МИАТ”ТӨХК-ийн Төв байр,
ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Б.Даваадорж Утас:7004-9852

Тав. Материал хүлээн авах хугацаа:

2020 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийг дуустал хүлээж авна.

Т.Элиса, Б.Дашням, Шинжээч

“Эдийн засаг хүндэрч, зайнаас ажиллах шаардлага тулгарч, үйлчилгээний газрууд зогсонги байдалд орсон энэ үед компани, ААН-үүдийг НДШ-ээс гурван сар ч болтугай чөлөөлж өгвөл том дэмжлэг болно” гэж MIBG компанийн гүйцэтгэх захирал А.Билгүүн ярилаа.



-Зах зээлд арилжаа хийдэг хүмүүс үнээ алдахгүйн тулд хошуурч байна. Зарим нь зах зээлийг орхиж байна. Монгол Улсын хэмжээнд үнэт цаасны зах зээлийг харахад “Мазаалай”, “Хуралдай” бондын хүү хэзээ ч байгаагүйгээр өсжээ. Яагаад ийм зүйл болоод байна вэ?

-Хөрөнгө оруулагчид гэлтгүй дэлхий дахинаараа сэтгэл зүйн шоконд ороод байна. Сэтгэл зүйн шок хүмүүсийг сонин үйлдэл хийхэд хүргэдэг юм байна. Жишээлбэл, баруунд ариун цэврийн цаас хомсдоо. Хэрвээ ариун цэврийн цаасыг америкчууд Хятадаас импортолж хэрэглэдэг байсан бол хомсдоно гэж бодож нөөцлөх нь зөв. Дундаж америк иргэн жилд 100 ширхэг ариун цэврийн цаас хэрэглэдэг гэж байгаа. Гэтэл тэр 100 ширхэг ариун цэврийн цаасных нь ердөө 10 хувийг л импортолдог. Хөрөнгө оруулагчдад ч гэсэн сэтгэл зүйн шок үүсээд байна. Хөрөнгө оруулалтын шийдвэрийг энгийн хүмүүс гаргаж байгаа. Харин хөрөнгө оруулагчид эрсдэлээс айж байна. Аль болохоор эрсдэлгүй байх, өсөх хөрөнгө рүү өнөөдөр шуурч эхэллээ. Зах зээлд зарим хөрөнгийн үнэ савлагаатай байгаа. Үүнийг эдийн засгийн суурь ухагдахууны талаас нь тайлбарлах боломжгүй болсон.

-Монголын Засгийн газар ойрын хугацаанд бондоо эргүүлж төлөх ёстой. Үүнтэй холбоотойгоор дахиад бонд гаргах болов уу гэсэн хүлээлт зардал өслөө. Ингэснээр шинэ жишиг тогтох болов уу, эсвэл өмнөх түвшин рүүгээ буух уу?

-Аливаа нэг тусгаар улсын бонд хоёр оронтой тооны өгөөжтэй байх тохиолдол урьд нь гарч байгаагүй. Магадгүй дампуурлын ирмэгт ирсэн улс орнуудад л харагддаг байсан үйл явдал байх. Манай бондын өгөөж харьцангуй өндөр тогтоно. Гэхдээ бид олон улсын хөрөнгийн зах зээлд бонд нэмж гаргах байдлаар санхүүжилт татах нөхцөл бүрдэх магадлал бий. Хөгжилтэй орнуудын төв банк дандаа мөнгө хэвлэж, дотоодын



Гэрэл зургийг С.Батсайхан

Манай бондын өгөөж харьцангуй өндөр тогтоно. Гэхдээ бид олон улсын хөрөнгийн зах зээлд бонд нэмж гаргах байдлаар санхүүжилт татах нөхцөл бүрдэх магадлал бий

эдийн засгаа сэргээж байгаа. Манай улс бондын өгөөжийг илүү өндөр болгохын тулд хөгжсөн орнуудынхтай холилж арга хэрэглэх нь зөв.

-Уул уурхай Монголын эдийн засгийн гол салбар. Тэгэхээр богино хугацаанд нүүрсний орлогоо нөхөж чадах болов уу?

-Богино хугацаанд нөхөх хэцүү. Нэгдүгээр сарын сүүлээс гуравдугаар сарыг дуустал хаачихлаа шүү дээ. Хоёр сарын экспортын орлогыг гүйцэж нөхнө гэдэг маш хэцүү асуудал. Гэхдээ урд хөршийн зах зээлд нүүрсний эрэлт байгаа болохоор экспорт гайгүй байх нь. Гэтэл 2020 оны дунд хугацааг харахаар зэсийн ханш унаад эхэллээ. Мөн кокосжих нүүрсний ханш унах вий гэсэн айдас байна. Дэлхийн эдийн засаг хоорондоо уялдаатай. БНХАУ-ын гаргаж буй бүтээгдэхүүнүүдийг Европын холбоо, Хойд Америкийн улсууд гээд хөгжингүй зах зээлтэй хэрэглэгчид авч байна. Гэвч хэрэглэгч улсуудад вирусийн тархалт нэмэгдэж, магадгүй 2-3 сараар сул зогсох нөхцөл байдал үүслээ. Энэ нь Хятадын компаниудад сөргөөр нөлөөлнө. Тиймээс урт хугацаандаа манай экспортын бүтээгдэхүүний үнэлгээ буурах магадлалтай.

-Цаг үе хүндрэлтэй байгаа нөхцөлд нэг цонхны бодлого хэрэгтэй юу?

-Мэдээж хэрэгтэй. Дотоодоосоо гарч байгаа хэмжээгээ ихэсгэхийн тулд нэг цонхны бодлого барих нь зөв. Энэ ч харагдаж байна. Хямралын үед нэг цул болж ажиллаж чадаж байгаа. Төр засаг нь үнэн зөв мэдээллийг цаг тухайд өгч байна. Иргэд төртэй хамтарч ажиллаж чадаж байгаа нь эндээс харагдлаа. Эрүүл мэндийн салбарт учрах эрсдэлийг тодорхой хэмжээгээр амжилттай давж байгаа туршлагыг аж үйлдвэрийн салбарт нэвтрүүлэх боломжтой юм байна гэж харлаа.

-Аж үйлдвэрийн салбар руу барууны гэлтгүй дэлхийн чадварлаг институттэй орнууд төсвийн болон хавсарсан бодлого хэрэгжүүлж байна. Мөнгөний бодлогоо зөөлөх, хэцүү байгаа салбараа зээлийн баталгаагаар дэмжиж байна. Харин манай төсвийн бодлого хэр оновчтой байна вэ?

-Хэсэг эдийн засагч төсвийн зардлыг танах хэрэгтэй гэж үзэж байна. Нөгөө хэсэг нь төсвийн зардлыг нэмэх ёстой гэсэн байр суурьтай байдаг. Миний хувьд богино хугацаанд төсвийг тэлэх шаардлагатай. Ингэхдээ урт хугацаанд өгөөжөө өгөх төслүүдэд хөрөнгө оруулах замаар тэлэх хэрэгтэй. Манай улсад нэг дутагдалтай зүйл бий.

ХЯТАД ХЭР ХЭМЖЭЭНИЙ МӨНГӨ ХЭВЛЭЖ ЗАХ ЗЭЭЛД НИЙЛҮҮЛЭХЭЭС ХАМААРААД МАНАЙ ЭРДСИЙН ИРЭЭДҮЙ ТОДОРХОЙЛОГ-ДОНО.

2012 онд эдийн засгийн байдал хүндэрч эхлэх үед төсвийн бодлогоороо эдийн засгаа сэргээх гэж оролдсон. Ингэхдээ улс төрийн зорилт тавьж, импортыг орлох, эдийн засгийг төрөлжүүлэх салбар руу хөрөнгө оруулахаар “Чингис” бондоос санхүүжүүлсэн. Энэ буруу шийдвэр том өр авчирсан. Эдийн засагт ээлтэй зүйл болоогүй.

-Төсвийг тэлэх бодлогыг аль салбар руу онилбол илүү үр дүнтэй вэ?

-Мэдээж уул уурхай. Уул уурхай манай улсын тэргүүлэх салбар бөгөөд олон улсын тавцанд өрсөлдөх чадвартай

болгож буй шүү дээ. Тэгэхээр уул уурхайн салбарынхаа олборлогч компаниудыг дэмжихийн зэрэгцээ ханган нийлүүлэгчдийг нь мөн харж үзэх хэрэгтэй. Ингэснээр тэр ажлын байрыг хамгаалж үлдэнэ.

-Уул уурхайн салбарын ажиллах хүчин одоогоор 50 мянга гаруй байна. Энэ нь бусад салбарынхаас бага тоо. Тэгэхээр бусад салбартаа нөлөөлж чадах болов уу?

-Нөлөөлнө. Уул уурхайн салбар зогслоо гэхэд банк санхүүгийн салбар зогсох эрсдэлтэй. Бусад үйлчилгээний салбарт ч сөргөөр нөлөөлнө. Орлогын эх үүсвэр хаана байна гэдгийг онилох нь чухал. Хямралын үед манай бодлого баригчид прагматик байдлаар нөхцөл байдалд хандах хэрэгтэй.

-Өнгөрсөн хоёр сарын хугацаанд эрдэс баялгийн салбараас улсын нэгдсэн төсөвт төвлөрүүлсэн дүнг харахад 2019 оны мөн үеийнхээс 10.6 хувиар буурсан байна. Төсвийн орлогын алдагдлыг нөхөх боломж бий юу?

-Тийм боломж байхгүй. Мега төслүүдийг хийгээд гаднын хөрөнгө оруулагчид орж ирэх нөхцөл боломжоор хангаж өгвөл давуу тал үүсэж магадгүй. Хөрөнгө оруулалтын чиглэлийн хэлцлүүд боломж авчирна.

-Өвчнөөс үүдсэн эдийн засгийн хямрал үүслээ. Манай Засгийн газар юу хийвэл оновчтой бол?

-Хөрвөх чадварын хямрал нүүрлээд байна. Манай улсын аж ахуйн нэгжүүдэд, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдэд ч тулгарч байгаа. Энэ эрсдэлээс гарахын тулд төв банк валют хэвлэж, зах зээлд гаргах, хөнгөлөлттэй зээл олгох хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ авч байна. Гэхдээ экспортын бүтээгдэхүүний үнэлгээ унана гэдэг хамгийн том эрсдэл.

-Эрсдэлийг давах, бизнесийг

дэмжихэд хэрэгжүүлж буй арга хэмжээнээс иргэд рүү юу, бизнесийнхэн рүү чиглэсэн нь оновчтой байна уу?

-Манай бодлого баригчид, ялангуяа мөнгөний бодлого хэрэгжүүлэгчдээс иргэд рүүгээ ч, аж ахуйн нэгж рүүгээ ч чиглэсэн хөтөлбөрүүдийг ярьж байгаа. Гэхдээ асар ойлгомжгүй, иргэд, ААН яаж хөтөлбөрт хамрагдах нь тодорхойгүй байна.

-Уул уурхайн салбарт гаднын хөрөнгө оруулалт татах боломж хэр харагдаж байна?

-Хөрөнгийн зах зээл дээр бүх хувьцаа хэрхэн унаж байгааг бид харлаа. Дийлэнх хөрөнгө оруулагч тухайн салбар ямар байгаагаас нь хамаарч хамтарч ажилладаг. 2009-2012 он хүртэл Монгол руу хөрөнгө оруулбал өсдөг гэсэн ойлголттой байлаа. Хөрөнгө оруулагчдын сэтгэл зүй ингэж ажилладаг л даа. Шинжээчийн нүдээр харахад аль ч IPO, шинээр үнэт цаас гаргах асуудал өнөөгийн зах зээлд хүндрэлтэй.

-Оюутолгой нэмэлт хөрөнгө оруулалт татах шаардлагатай гэж мэдэгдсэн. Гүний уурхай, Тавантолгойн цахилгаан станцад нэмэлт санхүүжилт шаардлагатай гэсэн. Энэ талаар мэдээлэл өгнө үү?

-Нийлээд 4.5 тэрбум орчим төгрөг нэмж татах шаардлагатай гэхээр нь Rio Tinto-гийн хувьцааны ханшийг харлаа. Гэтэл ханш нь унаад 36 орчим ам.доллар болсон байна. Өнгөрсөн жилийнх нь ногдол ашигтай харьцуулаад үзэхээр өгөөж нь 10 хувь л байсан. Ингэж хоёр оронтой тоо руу орсон нөхцөлд ямар ч том компани хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулна гэдэг асар хүндрэлтэй. Нөгөө талаасаа манай улсад тулгарах бэрхшээлийг харж үзээд донор байгууллагууд санхүүжилтийг эрчимжүүлэх бодлого барьж болох юм.

-Хятадаас хамаарал багатай өөр зах зээл рүү хуваарилах боломжтой юу?

-Томоохон хөрөнгө оруулагчид Хятадтай ойрхон болохоор л Монгол руу хөрөнгө оруулдаг. Хүнд үйлдвэрлэлд ашигладаг эрдсийн бүтээгдэхүүнүүдийг БНХАУ руу зардаг. Дэлхийн хамгийн том хэрэглэгч урд хөрш хэвээрээ л байна. Цар тахлын хямралаас үүдээд шинэ хандлага гарч ирж болох юм. Урд хөрш өвчний тархалтыг харьцангуй хохирол багатай давж байна. Мөн Азийн улсууд нэг цул болж чаддагийг харууллаа. Энэ бол хямрал дууссаны дараа давуу тал болно. Хятад хэр хэмжээний мөнгө хэвлэж зах зээлд нийлүүлэхээс хамаараад манай эрдсийн ирээдүй тодорхойлогдоно. Хятад эдийн засгаа аврахын тулд шийдэмгий алхам хийдгийг хөрөнгө оруулагчид мэдэх учраас Монголд илүү найдлага тавьж магадгүй гэсэн хүлээлт байна. ■

Томас Мюллер, Корин Гретье

COVID-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх боломжоо алдсан засгийн газрууд корона-вирустэй тэмцэх үнэт цаг хугацааг дэмий алдсаар байгааг зогсоох ёстой хэмээн Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (ДЭМБ) тэргүүн анхааруулав.

“Бид эхний боломжийг алдсан. Идэвхтэй ажиллах ёстой үе нь нэг, хоёр сарын өмнө байж” хэмээн ДЭМБ-ын Ерөнхий захирал Тедрос Аданом Гебресус мэдэгдлээ.

Уг мэдэгдэл нь өдгөө дэлхийн бараг бүх улсад илэрч 20,000



Дэлхий ертөнц цар тахлын нөхцөлд ажиллах бэлтгэлгүй байгааг ДЭМБ анхааруулав

- Сэжигтэй тохиолдлыг илрүүлэх тогтолцоо нэвтрүүлэх
- Оношлуурын үйлдвэрлэлийг эрс ихэсгэж, хүртээмжийг сайжруулах
- Коронавирусийн эмчилгээний төв болгон хувиргах боломжтой объектуудаа тодорхойлох
- Карантин-хөл хорионы дэглэмийн төлөвлөгөө боловсруулах
- Засгийн газар үйл ажиллагаагаа вирусийг дарахад чиглүүлэх гэв.

Түүнчлэн “Дэлхий цар тахалд бэлтгэлгүй байна” хэмээн захирал Райан тайлбарлав. Жишээ нь, ханган нийлүүлэх сүлжээ тасалдсанаар эмнэлгийн бээлий хомсдож болзошгүй.

Улс орнууд цар тахлын эсрэг арга хэмжээ авахдаа хугацаа алдаж байна

орчим хүний амийг аваад буй аюулт өвчний эсрэг дэлхийн тэмцэл ахиц муутай буйг ойлгуулах гэсэн сануулга болов. Тус байгууллага гишүүн улсуудаа ил тод шүүмжлэхээс аль болох зайлсхийж ирснийг онцгой байдлын хөтөлбөр хариуцсан захирал Майк Райан тайлбарласан юм.

Одоогийн байдлаар дэлхийн 150 улсад вирусийн халдварын тохиолдол 100-гаас цөөн бүртгэгдсэн учраас

бэлтгэх, бэлэн байх хугацаа болон хоёр дахь боломж бас ч байгааг ДЭМБ-ын тэргүүн онцлон дурдав. Тусгаарлах арга хэмжээ авсан улс орнууд вирусийн тархалтыг шийдмэг таслан зогсоох арга хэмжээ авч, цаг хожлоо. Тусгаарлалт хэр урт үргэлжлэх нь тухайн улс орон өвчний тархалтын эсрэг ямар арга хэмжээ авч буйгаас шалтгаална хэмээн Тедрос үзэж буй.

Хатуу тусгаарлалт нийгэм болон эдийн засгийн сөрөг

ТУСГААРЛАЛТ ХЭР УРТ ҮРГЭЛЖЛЭХ НЬ ТУХАЙН УЛС ОРОН ӨВЧНИЙ ТАРХАЛТЫН ЭСРЭГ ЯМАР АРГА ХЭМЖЭЭ АВЧ БУЙГААС ШАЛТГААЛНА.

нөлөөтэй. Гэхдээ “өвчний тохиолдол ихэссэний улмаас сургууль, албан байгууллагуудыг дахиад хаахад хүргэлгүйгээр нээх нь аль ч улсад чухал” гэдгийг Тедрос онцлон анхааруулав.

ДЭМБ-ын тэргүүн бүх улс авах ёстой доорх зургаан арга хэмжээг мөн дурдсан юм.

- Эрүүлийг хамгаалахын ажилтнуудын тоог ихэсгэж дадлагажуулан, хуваарилж ажиллуулах

Учир нь эмнэлгийн бээлийн түүхий эд-каучукийг дэлхийн хэдхэн улс нийлүүлдэг.

Дэлхий даяар эрүүлийг хамгаалахын ажилтан, ажилчдад хувийн хамгаалалтын хэрэгсэл дутагдаж байгааг ДЭМБ-ын тахал судлаач Мария Ван Керков тайлбарласан юм. Өвдөөгүй хүнд маск хэрэггүй, харин тухайн улсын хэрэглээнээс болоод эмч нарт маск хүрэлцэхгүй байж болохгүйг Ван Керков анхаарууллаа. ■

Нью-Йоркт нохой, муурны хомсдол нүүрлэв


Бэйли Липшульц

Коронавирусийн цар тахлын улмаас хомсодсон зүйл гэхээр ариун цэврийн цаас, гар ариутгах шингэн, савласан ус санаанд ордог. Тэгвэл гайхаад барамгүй хачирхалтай нь нохой, бас муур үүнд багтаж байна.

Вирусийн халдварын голомт болон Нью-Йорк хотын бүсэд гэнэт тэжээх амьтан олдохоо болив. Сүүлийн хоёр долоо хоногт тэжээх амьтан авах хүсэлтийн тоо 10 дахин өссөнтэй уялдан нохой, муурын “бэлэн нөөц” хэдийн дууссаныг амьтан асарч тэжээх ажил эрхэлдэг Muddy Paws Rescue, Best Friends Animal Society гэсэн хоёр байгууллага мэдэгдлээ.

Орон гэртээ тусгаарлагдан байх уйтгартай бөгөөд айдастай тушаал авсан Нью-Йоркийн оршин суугчид дөрвөн хөлт андыг мэдрэл, нервээ тайвшруулах хэрэгсэл хэмээн үзэж байна. “Одоо манайд ганц ч нохой үлдээгүй” хэмээн Muddy Paws-ын маркетинг эрхэлсэн захирал Анна Лай өгүүлэв.

Хувьцааны зах зээл нийтээрээ хямралтай ийм нөхцөлд тэжээвэр амьтны хоол тэжээл үйлдвэрлэгч Chewy Inc-ийн хувьцааны үнэ



өссөөр буйн шалтгаан нь энэхүү хомсдолоос улбаатай болох нь. Үйлчлүүлэгчдийн цар хүрээ өргөжиж, онлайн захиалга нэмэгдсэн Chewy Inc-ийн хувьцааны үнэ он гарснаас хойш долоон хувиар өсөөд байна. Ачаалал ихэссэнтэй уялдан үйлчлүүлэгчдийнхээ захиалгыг 7-10 хоногт багтааж биелүүлнэ гэдгийг тус компани вэбсайтаа анхааруулжээ.

Гэртээ амьтан тэжээх хүсэл Нью-Йоркийн зэрэгцээ вирус тархсан бусад хотод ч ихэссэн юм. Тэжээгчтэй болсон дөрвөн хөлт амьтдын тоо Лос-Анжелесын салбарт нь мөн адил 70 хувиар нэмэгдсэнийг “Амьтдад харгис хандахаас сэргийлэх Америкийн нийгэмлэг” (American Society for

the Prevention of Cruelty to Animals) тооцоолжээ. АНУ даяар амьтан асарч тэжээдэг олон байгууллагад нөхцөл байдал адил байгааг Best Friends тайлбарласан юм.

Нохой, муурын эрэлт түр ихэссэн ч байдал удахгүй эсрэгээр эргэж, ажилгүй болсон америкчууд тэжээвэр амьтнаа авчирч өгөх нь ихэсж болзошгүй хэмээн АНУ-ын амьтан хамгаалах байгууллагууд түгшиж байна. “Эдийн засаг муудах үед юу болохыг таашгүй” хэмээн Колумбын тойрог, Нью-Жерси муж улсын тэжээвэр амьтан асарч хамгаалах төвүүдийг нэгтгэдэг Humane Rescue Alliance-ын гүйцэтгэх захирал Лайза ЛаФонтен тайлбарлав. ■

Тренд маск \$200 хүрлээ

Лизетт Чэпмен

Гвинет Пелтроу фермерээсээ харьж яваа гэрэл зургаа даваа гарагт Instagram-д байршуулжээ. Зурагт тэрбээр хар даашинзтайгаа өнгө зохицсон хар маск зүүлттэй гарсан юм. Уг нь хар маск Шведийн Airinum AB компанийн загвар.

Коронавирусийн цар тахал дэгдсэн энэ үед амны маск зарим баян чинээлэг хүмүүсийн аксессуар гоёл болж хувирлаа. **Эмнэлгийн ажилтнуудад хувийн хамгаалах хэрэгсэл ноцтой дутагдаж буй нөхцөлд амны маск тэгш бус байдлын илрэл хэмээн зарим нь шүүмжилж байна.** Airinum болон Cambridge Mask Co, Vogmask зэрэг тренд амны маск үйлдвэрлэгчид агаар шүүх дэвшилтэт систем, хэрэглэгчийн хамрын хэлбэрт тохируулсан хөсөнцөр хэв бүхий төрөл бүрийн өнгө, загвартай бүтээгдэхүүн борлуулдаг. Дээрх компаниудын загвар нь угаагаад дахин хэрэглэж болдог хөвөн цаасан маскаас ялгаатай юм.

Үнийн хувьд Cambridge-ын



энгийн хар маск 12 ам.доллар, Airinum-ын сувдан ягаан загвар 69 ам.доллар байх жишээтэй. Тус хоёр компанийн бэлэн бүтээгдэхүүний нөөц хэдийн шавхарсан тул худалдаж авах гэвэл ирэх сараас наашгүй. Өнгөрсөн долоо хоногт Airinums компани маскаа EBay-д ширхгийг нь 200 гаруй ам.доллараар, Vogmasks дунджаар 150 ам.доллараар заржээ. Амны маск, гар ариутгах шингэн зэрэг чухал хэрэгцээт бүтээгдэхүүний үнэ өсгөх боломжийг борлуулагчдад олгож байна гэсэн шүүмж хүлээсэн EBay Inc, Amazon.com Inc цаашид ийм төрлийн зарыг хориглохоо мэдэгдэв. Гэтэл дээрх компаниудын бүтээгдэхүүн нь стили, дизайны хувьд люкс ангиллын бүтээгдэхүүн тул цаашдаа хар захын бараа болж болзошгүй. ■

Хөрөнгийн зах зээл дээр хэрхэн амжилттай “тоглох” вэ

Бонд худалдан авах нь тухайн компанид та зээлдүүлэгч болж буй хэрэг



Т.Намуун, ЗГМ сонин

Сүүлийн жилүүдэд компаниуд хувьцаагаа олон нийтэд санал болгох нь эрс нэмэгдсэн. Хувьцаа арилжиж, тэрбумтан болсон хүмүүс ч цөөнгүй. Гэвч бодит байдал дээр иргэдийн дийлэнх нь хөрөнгийн зах зээлийн мэдлэггүйн улмаас санхүүгийн хохирол амсах нь түгээмэл байдаг. Тиймээс уншигчдадаа зориулж хувьцаа худалдан авахдаа анхаарах зүйлсийг бэлтгэлээ.

ХУВЬЦАА БА БОНДЫН ЯЛГАА

Хөрөнгийн зах зээлд бонд болон хувьцаа гэсэн санхүүгийн үндсэн хоёр хэрэгслийг арилжаалдаг. Хувьцаа урт хугацаанд үр өгөөжөө өгдөг бол бонд тодорхой хугацаанд тогтмол хүүгийн орлого өгдөг. Та хувьцаа худалдан авснаар тухайн компанийн эзэмшигч болж, жил бүр ногдол ашиг авах, хувьцаагаа өссөн үед нь арилжиж, ханшийн зөрүүнээс ашиг олох боломжтой.

Хувьцааг дотор нь энгийн болон давуу эрхийн хувьцаа гэж ангилдаг. Энгийн хувьцаа эзэмшигч ханшийн зөрүүнээс ашиг олдог. Харин тухайн

Хувьцаа худалдан авснаар тухайн компанийн эзэмшигч болж, жил бүр ногдол ашиг авах, хувьцаагаа өссөн үед нь арилжиж, ханшийн зөрүүнээс ашиг олох боломжтой.

компани ногдол ашиг хуваарилах бодлого баримталж байгаа бол энгийн хувьцаа эзэмшигчийн хүртэх өгөөж тэр хэмжээгээр нэмэгдэнэ. **Давуу эрхтэй хувьцаа өрийн хэрэгсэлтэй адил тогтмол орлоготой байх ба энгийн хувьцаанаас ялгаатай нь компанийн үйл ажиллагаанд оролцох боломжгүй.**

Харин бонд худалдан авах нь тухайн компанид та зээлдүүлэгч болж буй хэрэг бөгөөд хүүгийн орлогоор ашиг олдог.

СОНГОЛТ

Бирж дээр хувьцаанууд харилцан адилгүй үнээр зарагддаг бөгөөд тухайн үнийн дүн нь зах зээлийн бодит үнэлгээ мөн эсэхийг тодорхойлох хэрэгтэй. Жишээлбэл, томоохон компанийн нэг ширхэг хувьцаа 200 мянган төгрөг байхад өөр компанийн хувьцаа 500 төгрөг байх жишээтэй. **Хувьцааг зах зээлийн үнээс бага эсвэл ихээр үнэлэх нь түгээмэл бөгөөд үүнийг санхүүгийн суурь шинжилгээгээр тодорхойлдог.**

ХЭРХЭН ХУДАЛДАН АВАХ ВЭ

Хувьцаа эзэмшихийн тулд та Монголын хөрөнгийн биржийн гишүүн брокер, дилерийн компаниудаас сонголт хийж, дансаа нээлгэнэ. Ингэснээр өмч хөрөнгийн захиран зарцуулах эрх нээгдэж, арилжаа хийх боломжтой болно. ■

ХУВЬЦАА, БОНД ХУДАЛДАН АВАХДАА АНХААРАХ ЗҮЙЛС



- Таны хувьцааг нь авч буй компани олон жил үйл ажиллагаагаа явуулж, тогтвортой ажилладаг компани байх хэрэгтэй. Тиймээс тухайн компанийн санхүүгийн тайлантай танилцаж, орлого, ашгийн үзүүлэлт нь урт хугацаанд өсөлт үзүүлэх эсэхэд шинжилгээ хийгээрэй.

- Компанийн үйл ажиллагааны түүх, байр суурь, амжилт, удирдлагын ур чадвар, туршлага, зэрэг өнгөрсөн үеийн мэдээллийг сайтар судал.

- Хувьцаа эзэмшигчдийн хурлаа хугацаанд нь хийдэг эсэх

- Мэдээллийн ил тод байдлыг ханган ажилладаг эсэх

- Тухайн байгууллагын харьяалагдах салбарын нөхцөл байдал, эрсдэлт хүчин зүйлүүдийг харгалзан үзэх (эрх зүйн орчин, салбарын өсөх боломж гэх мэт)

- Бусдын ятгалгад автах хэрэггүй

- Ногдол ашгаа тараах хэтийн төлөвлөгөөг нь анхаар. Жишээлбэл, та тогтмол ногдол ашиг авах сонирхолтой байхад тухайн компани богино хугацаанд ногдол ашиг тараахгүй байх бодлого баримталж болно.

- Хувьцаа бол урт хугацааны хөрөнгө оруулалт гэдгийг сана.

- Хувьцаа худалдан авсан бол та хөрөнгө оруулсан компанийнхаа үйл ажиллагаа, зах зээлийн нөхцөлд анхаарал хандуулж, худалдах боломжтой хугацааг ажиглаж байх хэрэгтэй. ■

ТЭРБУМТНААС СУРАЛЦЬЯ

Ганцхан өдрийн дотор \$1 тэрбум олсон Жорж Сорос

АНУ-ын тэрбумтан, 8.3 тэрбум ам.долларын хөрөнгөтэй, үнэт цаасны зах зээлийн томоохон тоглогч Жорж Соросын түүхийг танилцуулъя. Өдгөө 90 настай тэрбээр унгар гаралтай бөгөөд 1946 онд Англи руу дүрвэж, Лондоны эдийн засгийн сургуулийг төгссөн. Улмаар 1956 онд АНУ-д цагаачлан санхүүгийн ертөнцөд хөл тавьж байлаа. Жорж мөнгөний ханш хаана унаж, хаана өсөхийг урьдчилан таамаглаж, орон орны банкны хувьцааг арилжсаар арван жилийн дотор мөнгөө 4000 хувиар өсгөж чадсан юм.

Тэрбээр 1992 оны есдүгээр

сарын 16-ны өдөр Их Британийн фунт стерлингийн ханшийг унагаах ажиллагаа зохион байгуулж, 12 хувьд хүргээд тэрхүү уналтаас ганцхан өдрийн дотор нэг тэрбум ам.долларын ашиг олж байв. Түүнийг эл явдлаас нь улбаалан “Английн банкныг дампууруулагч” хэмээн хочилдог болсон. Харин ханшийн уналтын тэрхүү өдрийг “Хар лхагва гариг” хэмээдэг. Жорж Сорос хүмүүнлэгийн үйл ажиллагаанд мөнгө зардгаараа алдартай бөгөөд өөрийн сангаар дамжуулан 2018 оны байдлаар нийт 18 тэрбум ам.долларыг хүмүүнлэгийн үйл ажиллагаанд хандивласан байна. ■



ҮНЭРТНИЙ ЕРТӨНЦӨӨР



Опра Уинфри: Kai

Медиа салбарын “тэргүүн хадагтай”, домогт Опра Уинфри цагаан цэцэгсийн анхилуун үнэртэй энэхүү сүрчгийг өдөр тутамдаа түрхэх дуртай. Өндөр ачаалалтай, завгүй ажилладаг түүний хувьд Kai-ийн тосон сүрчиг тайвшруулах мэдрэмж өгдөг аж. Kai гэдэг нь хавай хэлээр “далай” гэсэн утгыг илэрхийлдэг.



Мишель Обама: Creed Love in White

АНУ-ын тэргүүн хадагтай асан Мишель Обамагийн таашаадаг Love in White сүрчгийг алдарт зохион бүтээгч Оливер Крип далайгаар аялж байхдаа бодож болжээ. 1760 оноос үүсэлтэй Creed брэнд бол сүрчгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, үе удам дамжсан цөөн тооны хувийн компаниудын нэг юм. Тусгай жороор бүтээдэг энэхүү брэндийн сүрчгүүдийг гоо зүй, үнэртний өндөр мэдрэмжтэй улс төр, бизнес, спорт, урлагийн салбарын тэргүүлэгчид сонгодог.

Рианна: Love, Don't Be Shy Kilian

Ваниль, чихрийн нишингэ, хөөсөн чихрийн үнэртэй энэхүү сүрчиг анх 2007 онд худалдаанд гарч байв. Урлагийн салбараас гадна, гоо сайхны зах зээлд Fenty beauty брэндээрээ хүч түрэн орж ирсэн, дуучин Рианнагийн хамгийн дуртай сүрчиг Love, Don't Be Shy нь эрч хүчтэй, дайчин байдлыг илтгэдэг.



Эмэгтэй хүн, сайхан үнэр хоёр салшгүй холбоотой

Германы Statista судалгааны байгууллагын тооцоолсноор, өдгөө 43.9 тэрбум ам.доллараар хэмжигдэж буй дэлхийн сүрчгийн зах зээл 2025 он гэхэд 52.4 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна. Одоогоор Coty Inc, L'Oreal, LVMH, Estee Lauder зэрэг брэнд хүчирхэг стратеги, томоохон худалдан авалт, нэгтгэл, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлтээрээ энэ зах зээлд ноёлж буй. Эдгээрээс гадна, орц найрлага, чанар, тусгай жороороо үнэнч хэрэглэгчтэй болсон онцгой брэндүүд ч бий. “Сүрчиг бол дурсамж сэргээх урлагийн бүтээл” гэж Jean Paul Gaultier, Elie Saab, Burberry, Nina Ricci зэрэг тансаг зэрэглэлийн брэндүүдэд хамгийн өндөр борлуулалттай сүрчгүүдийг нь зохион бүтээж өгсөн Франсис Куркжан тодорхойлдог. Тэр тусмаа эмэгтэй хүн сайхан үнэр хоёр салшгүй холбоотой. Энэ жишгээр, дэлхийд алдартай, нөлөө бүхий эмэгтэйчүүд ч гэсэн өөрийн дуртай үнэр, таашаадаг сүрчигтэй байх нь ойлгомжтой.



Хиллари Клинтон: Thierry Mugler Angel

Анх 1992 онд гаргасан Angel сүрчиг нь элсэн чихэрт хуурсан самар болон шоколад хосолсон хурц үнэрээрээ эмэгтэй хүний сүр хүч, бардам байдлыг илтгэдэг. Олны таашаалд нийцүүлж гаргаагүй энэхүү сүрчиг зарим хүмүүст таагүй санагддаг бол зарим хүмүүсийг харин ч бүр “донтуулдаг” аж.



Бейонсе: Emporio Armani Diamonds

Италийн загвар зохион бүтээгч Жоржио Арманигийн, эмэгтэйчүүдэд зориулсан Diamonds сүрчиг анх 2007 онд худалдаанд гарч байв. Шүүслэг бөөрөлзгөнө, сарнай цэцэг, ванилийн үнэрийг нэгтгэсэн Diamonds сүрчиг эмэгтэй хүний дур булаам байдлыг тодотгодог.



Эллен Деженерес: Diptyque Philosykos

Эрэгтэй, эмэгтэй аль алинд нь зориулагдсан, модны тайвшруулах үнэртэй энэхүү сүрчиг 1996 анх танилцуулагдсанаас хойш өндөр эрэлттэй хэвээр байна. Телевизийн шоуны домогт хөтлөгч, хөгжилтэй зан, өрөвч зөөлөн сэтгэлээрээ олны хүндэтгэл хүлээлдэг тэрбээр Philosykos-ийг өдөр тутамдаа түрхдэг. ■



Б.Бурмаа: Өөрсдөө вирусийн халдвар авах эрсдэлтэй ч бид мэргэжилдээ хайртай

Эмнэлзүйч эмч нарын маань 70 шахам хувь нь өвчтөндтэйгээ хамт тусгаарлалтад ороод байна. Хэрэв байдал хүндэрвэл эмч нар хүрэлцэхгүй байх эрсдэл бий



Гэрэл зургийг С.Батсайхан

Г.Баярсайхан, ЗГМ сонин

Коронавирусийн цар тахлын үед галын шугаман дээр ажиллаж, аюултай нүүр тулж буй хүмүүс бол халдвартын эмч нар. Хаана өвчин гарна, хаана сэжигтэй тохиолдол бүртгэгдэнэ тэр бүхэнд ХӨСҮТ-ийн эмч нар дайчлагдан ажилласаар байгаа. Эдгээр эмч нарын төлөөлөл болгож ХӨСҮТ-ийн Гуравдугаар тасгийн их эмч Б.Бурмаатай ярилцлаа.

-Одоогоор ХӨСҮТ-д хэдэн хүн тусгаарлагдаж, хэд нь эмчилгээ хийлгэж байна вэ?

-Одоогоор манай эмнэлэгт нийт 353 эмчлүүлэгч байгаагаас халдвартын клиникт 215, үүнээс COVID-19 халдварын эмчилгээ болон ажиглалт, тусгаарлалтад 184 хүн байна. Ерөнхийдөө хөл хорио тогтоосноос хойш улсын хэмжээнд тусгаарлагдсан, сэжигтэй тохиолдлуудыг тооцвол 2000 гаруй хүн болсон. Манай эмнэлэг нийт зургаан тасагт COVID-19 халдварын сэжигтэй болон хавьталт, ажиглалтын гэсэн тохиолдлуудаар тусгаарлалт хийж байгаа.

Манай улс тусгай үүргийн онгоцоор гадаадад байгаа иргэдээ авчирч байгаа шүү дээ. Эндээс халуурсан, хоолой өвдсөн, цээжээр хөндүүрлэсэн, амьсгалын дутмагшил үүссэн хүмүүсийг долдугаар тасагт авдаг. Хэрэв вирусийн халдвар илэрвэл тэр хүмүүсийн нэг, хоёрдугаар хавьтлуудыг



мөн ХӨСҮТ-д тусгаарлана. Үүнээс гадна эрсдэлтэй бүс нутгаас ирсэн хүмүүс бий. Тэднээс зовуурь илрээгүй бол

ажиглалтад авч, амралт, сувиллын газруудад тусгаарлаж байгаа. Хэрэв ямар нэг эмнэлгийн тусламж шаардлагатай бол Цэргийн төв эмнэлэг буюу госпитальд тусгаарлах арга хэмжээ авч байна.

Манай эмнэлэгт энэ халдвартай холбоотой таван отряд ажиллаж байгаа. Отрядын бүрэлдэхүүн аяллаар явсан, гадагш зорчоод ирсэн иргэдийг үзээд, ялгаж салгана. Отрядын бүрэлдэхүүнд хоёр халдвар судлагч, хоёр эмнэлзүйч, хоёр ариутгагч, дарга, жолооч гээд

7-8 хүн багтдаг.

-Эмч нарын хүрэлцээ хэр байна?

-Манай улс гуравдугаар сарын эхээр хилээ бүрэн

хаасан шүү дээ. Гуравдугаар сарын дундаас тусгай үүргийн онгоцууд ирсэн тул энэ үеэс хойш ачаалал эрс нэмэгдэж, тул ажиглалтын зарим хүнээ бусад амралт, сувиллын газрууд руу явуулахаас аргагүй болсон. Мэдээж ачаалал их байна. Ер нь эмнэлзүйч эмч нарын маань 70 шахам хувь нь өвчтөндтэйгээ хамт тусгаарлалтад орсон. Нэг өвчтэй хүн илэрлээ гэхэд эмнэлзүйч эмч, ариутгагч эмч, сувилагчтайгаа баг болж ажилладаг. Энэ багийнхан эмчилгээний дараа өөрсдийгөө дахиад 14 хоног тусгаарлана. Өвчтэй хүнтэй харьцсан учраас өөрсдөө халдвар авсан байх эрсдэлтэй шүү дээ.

Анхны отряд нэгдүгээр сарын 23-нд Москвагаас ирсэн галт тэрэг тосож байлаа. Тэр үед 25 хүнийг эмнэлэгтээ авчирч, тусгаарлалтад авсан. Энэ үеэс хойш отрядууд олон ч газар очиж ажиллалаа.

-Эмнэлзүйч эмч нарын 70 шахам хувь нь тусгаарлагдсан гэлээ. Муугаар бодоод байдал хүндэрвэл эмч нар хүрэлцэхгүй байх аюул ойрхон юм байна, тийм үү?

-Манай улс сэргийлэх арга хэмжээг маш сайн авч чадсан. ХӨСҮТ, Зоонозын

шинжилгээ хийж байна. Мөн уушгины хатгаагаар хүнд өвдсөн хүмүүст шинжилгээ хийсний үндсэн дээр ямар ч байсан Монгол Улсад зөөвөрлөгдөхөөс бусад тохиолдлоор халдвар тархаагүй юм байна гэсэн дүгнэлт хийсэн.

Хэрэв урьдчилан сэргийлэлтийг сайн хийж чадалгүй халдвар тархаасан бол нөхцөл байдал хүндрэх нь ойлгомжтой. Манайх чинь хөгжиж байгаа орон. Бусад хөгжингүй орнуудтай харьцуулахад эмнэлгийн тусламжийн тоног төхөөрөмж, урвалж бодисоо авахад хүндрэл үүснэ.

Сүүлийн үед манай эмч нар цаг наргүй ажиллаж байгаа. Отрядын баг тогтмол жижүүрлэж хонодог. Иргэдээс ирсэн дуудлагын дагуу утсаар байнга зөвлөгөө өгч байна. Ер нь аливаа өвчнийг гарсан хойно нь эмчлэх биш, урьдчилан сэргийлэх нь ямар чухал болохыг энэ хэдэн өдрүүдэд монголчууд сайн ойлгосон байх.

-Ер нь нэг жилд халдварт өвчний чиглэлээр мэргэшсэн хэдэн эмч төгсөж гардаг вэ. Боловсон хүчний нөөц хангалттай байж чадах уу? Элдэв халдварт өвчин ойр ойрхон гараад байгаа болохоор ингэж асуулаа,

-Халдвартын чиглэлээр жилдээ 20 гаруй, сүрьеэгийн чиглэлээр 10 гаруй хүн бэлтгэгддэг юм билээ. Мэдээж төгсөж гарсан бүхэн ХӨСҮТ-д ажиллахгүй. Хөдөө орон нутагт хуваарилагдана, дүүргийн эмнэлгүүдэд ажиллана. Боловсон хүчин тодорхой хэмжээнд бэлтгэгдэж л байгаа. COVID-19 вирус дэгдэхээс өмнө бол манай халдвартын эмч нар хангалттай байсан. Харин өнөөдрийнх шиг онцгой тохиолдлын үед хүн хүч дутмаг байна. Сүрьеэгийн эмч бол байнга л дутагдалтай байдаг. Манай улс чадах чинээндээ бэлддэг ч бас л хангалтгүй хэвээр байгаа. Хүнийг заавал

**ИБУПРОФЕН
ХЭРЭГЛЭЖ
БОЛОХГҮЙ,
ЗӨВХӨН
ПАРАЦЕТАМОЛ
УУХ ЁСТОЙ ЮМ
ГЭСЭН МЭДЭЭЛЭЛ
ГАРСАН.
ЭНЭ ТАЛААР
АЛБАН ЁСООР
БАТЛАГДСАН
ЗҮЙЛ
ОДООХОНДОО
АЛГА.**

энэ чиглэлээр сур гэж албадаж болохгүй болохоор ирсэн хэдийгээ л бэлтгэн гаргаж байна.

-Коронавирусийн тархалт ханиад томууны ид үетэй давхацлаа. Ханиалгаж, халуурсан хүн бүр өөрсдийгөө корона-вирус авчихсан байж магадгүй гэж айдаг. Ер нь халуурч, ханиалгасан бүхэн танайд хандах ёстой юу?

-Мэдээж хүйтний үе учраас улирлын томуу давхар дэгдэж байгаа. Үүнтэй зэрэгцээд COVID-19 вирусийн тахал дэгдчихлээ. Тиймээс ханиаж, халуурсан ч гэсэн тухайн хүн эрсдэлтэй бүс нутагт зорчоогүй бол хамгийн түрүүнд өрхийн эмчдээ хандах ёстой. Гэхдээ одоо бид гэртээ өөрийгөө ажиглаж, утсаар зөвлөгөө ав гэж зөвлөж байгаа. Бид эхний ээлжинд утсаар зөвлөгөө өгнө, шаардлагатай бол дуудлагаар очиж үзнэ. Тиймээс яарч сандран эмнэлэгт битгий ир, онц шаардлагагүй бол эмнэлгээр битгий яв. Учир нь эмнэлгүүд өөрөө эрсдэлтэй бүс болчихоод байна. Хэрэв эрсдэлтэй бүс нутгаас зорчиж ирээд халуурч байгаа бол ХӨСҮТ-д яаралтай хандах нь зүйтэй.

Гэхдээ энэ халдвар гарснаас хойш эмнэлэгт ирж үйлчлүүлэх хүний тоо харьцангуй багассан. Өмнө нь манай Яаралтай тусламжийн хүлээн авахаар өдөрт дор хаяж 80-100 хүн үйлчлүүлдэг байсан бол одоо 30-40 хүн болж буурсан.

-Энэ вирусийг дэлхий дахинд хэрхэн эмчилж байна вэ. Манай эмчилгээний онцлог бусад улс оронтой адилхан уу, эсвэл өөр аргаар эмчилж байгаа юу?

-Энэ бол шинэ халдвар учраас яг тогтсон, өвөрмөц эмчилгээ гэж байхгүй. Ерөнхийд нь шинж тэмдгийн эмчилгээ хийнэ. Харин ямар хүндрэл гарвал тухайн хүний аль эрхтэн системийн тал дээр хүндрэл үүсэж байна, түүнийх нь дагуу эмчилж байгаа. Бид ч адилхан. Мэдээллээс харахад улс орнууд янз янзын л эмчилгээ туршиж байна. Ретровирусийн эмчилгээ үр дүнд хүрэх нь үү гэж туршиж байна. Мөн уламжлалт анагаах ухааны аргаар эмчлэх гэж оролдож байгаа тохиолдлууд ч бий. Яг ийм эмчилгээг тэд хоногийн хугацаанд хийж, ингэж эмчилнэ гэсэн тогтсон зүйл одоогоор алга.

-Өвчин нь хүндэрсэн хүнийг эмчлэх амьсгалын аппарат ихэнх улс оронд дутагдалтай байна. Амьсгалын аппарат хүрэлцэхгүйгээс болж иргэдээ олноор нь алдсан улс ч бий. Харин манайд энэ аппарат хүрэлцээтэй юу?

-Манай эрчимт эмчилгээний тасаг 5-6 өрөөтэй. Ор болгондоо амьсгалын аппараттай. Сая ЭМЯ-наас 10 аппарат нэмж өгсөн. Мөн зөөврийн



☉
Гуравдугаар сарын дундаас тусгай үүргийн онгоцууд ирэх болсон. Энэ үеэс хойш ачаалал эрс нэмэгдсэн. Манай шуурхай отрядын баг олон ч газар очиж ажиллалаа.

рентген аппарат ч өгсөн. Ер нь хандив тусламж болон улсын санхүүжилтээр тоног төхөөрөмжөө хангаж л байна. Одоогоор биеийн байдал нь хүндэрч, аппаратад орох хэмжээнд хүрсэн хүн алга.

-Сэжигтэй тохиолдол илэрсэн үед гэрээр эмчилгээ хийлгэх зөвлөмж гарсаар байна. Тэнд бичсэнээр бол лопинавир, ритонавир эмийг уух нь хамгийн үр дүнтэй гэх юм. Энэ зөвлөгөөг дагах нь зөв. Эдгээр эм нь Монголын эмийн сангуудад зарагддаг уу?

-Бид өвдсөн тохиолдолд заавал эмчийн заавраар эм уух ёстой гэдгийг иргэд маш сайн ойлгох хэрэгтэй. Тухайн хүн ямар нэгэн антибиотик хэрэглэх, вирусийн эсрэг эм уух шаардлагатай байна уу гэдгийг эмчийн заавраар л шийдэх ёстой. Тэгж байж эмийн зохистой хэрэглээ болно. Гэтэл манай иргэд хэн нэгний зөвлөгөөгөөр дурын антибиотик хэрэглэдэг. Тиймээс иргэдэд хандан "шаардлагатай бол утсаар зөвлөгөө ав, бүр болохгүй бол дуудлагаар очиж үзье" гэж хэлээд байгаа юм. Харин энд тэндээс уншиж сонссоноо дагаад, эмчийн зааваргүйгээр дураараа эм ууж огт болохгүй. Хүн гэдэг хогийн сав биш шүү дээ.

Хаа очиж хүмүүс корона-вирусийн нөлөөгөөр хувийн ариун цэврээ сахиж сурч байна. Ядаж л хүн бүр маск зүүж, гараа сайн угааж сурлаа. Бидний амнаас гарч буй нус, цэр эргээд өвчин дэгдээх эрсдэлтэй гэдгийг ойлгодог боллоо. Хандлагаа өөрчилж чадсаны ачаар гэдэсний халдвар, улирлын томуу зэрэг бусад халдварт өвчин тодорхой хэмжээгээр буурлаа. Ялангуяа амьсгалын замаар, бохир гараар халдварладаг өвчүүд маш их буурсан. Одоо монголчууд энэ

**ХАНИАЖ,
ХАЛУУРСАН Ч
ГЭСЭН ТУХАЙН
ХҮН ЭРСДЭЛТЭЙ
БҮС НУТАГТ
ЗОРЧООГУЙ Л БОЛ
ЯАРЧ САНДРАН
ЭМНЭЛЭГТ
ОЧИХ ХЭРЭГГҮЙ.
УЧИР НЬ
ЭМНЭЛЭГ ӨӨРӨӨ
ЭРСДЭЛТЭЙ БҮС
БОЛЧИХООД
БАЙНА. ТИЙМЭЭС
ЭХНИЙ ЭЭЛЖИНД
ГЭРТЭЭ ӨӨРИЙГӨӨ
АЖИГЛАЖ,
УТСААР
ЗӨВЛӨГӨӨ АВАХ
ХЭРЭГТЭЙ. ХЭРЭВ
ШААРДЛАГАТАЙ
БОЛ ДУУДЛАГААР
ОЧИЖ ҮЗНЭ.**

чигээрээ зөв дадал хэвшилтэй байвал үр дүнд хүрнэ.

-Энэ вирусээр өвчилж, халуурсан үед парацетамол уух нь хамгийн үр дүнтэй гэж бичээд байна. Энэ үнэн үү?

-Энэ бол батлагдаагүй мэдээлэл. Ибупрофен хэрэглэж болохгүй, зөвхөн парацетамол л уух ёстой гэх мэт мэдээлэл байсан. Энэ талаар албан ёсоор батлагдсан зүйл одоохондоо алга.

-Халдвартын эмч бол тийм ч хүсмээр мэргэжил биш. Цалин өндөр биш хэрнээ асар их эрсдэл дунд ажилладаг. Ер нь энэ ажлын зовлон, жаргал нь юу вэ?

-Эмч бол хамгийн сайхан мэргэжил. Яагаад гэвэл, бид хүмүүст эрүүл амьдрал бэлэглэдэг. Хэрэв өвдөөд ирвэл эмчилж эдгээнэ. Мөн өвдөхөөс нь

өмнө урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, зөвлөгөө мэдээлэл өгдөг. Бусдад тусалж, бусдыг аюулт өвчнөөс аварч байгаа гэдэг утгаараа бидний хувьд маш бахархалтай мэргэжил.

Би анагаахын сургуулийг 1999 онд төгсөөд Дорнод аймгийн Халхгол суманд гурван жилийн турш нөхөртэйгөө цуг ажиллаж байлаа. Нөхөр маань мэс засал, дотор, гэмтлээ хариуцна. Харин би хүүхдийн тусламж, эх барих эмэгтэйчүүдийн тусламж үзүүлнэ. Тэнд ажилласан гурван жилийн хугацаанд ихийг сурсан даа. Сумын эмнэлэгт ажиллах сайхан л юм билээ. Эмчийг маш их хүндэлнэ. Дараа нь аймгийн төвд халдвар судлагчаар жил орчим ажилласан. Харин 2003 оноос хүртэл Дорнод аймгийн бүсийн оношилгооны төвд халдвартын эмчээр ажиллаж байгаад 2010 онд ХӨСҮТ-д ирсэн дээ.

Мэдээж аливаа мэргэжилд эрсдэл бий. Гэхдээ эмчилгээний үеийн дүрэм журмаа сайн сахиж, хамгаалах хувцас хэрэглээ зөв өмсвөл халдвараас өөрийгөө хамгаалж чадна. Бид гараа эвэршиж хуурайштал гараа ариутгана шүү дээ. Дуудлаганд явахдаа хамгаалалтын хувцас өмсөөд очдог болохоор санаа зоволтгүй. Харин ирээд тайлахад л асуудал үүснэ. Халдвартай газраар явж, эрсдэлтэй хүмүүстэй харьцсаны дараа хамгаалалтын хувцсаа буруу тайлах юм бол өөрөө халдвар авах аюултай.

Гэхдээ хэдий эрсдэлтэй ч гэсэн бид мэргэжилдээ дуртай учраас ямар ч эрсдэлийг даваад гарах ёстой. Энд өвчин гарчихлаа, би яана аа гэж айж зугтаад байж болохгүй. Нэгэнт тангараг өргөсөн эмч учраас бусдад туслахын төлөө өөрт байгаа бүх л нөөц бололцоогоо ашиглан ажилладаг.

-Сэжигтэй тохиолдлоор

танайд тусгаарлагдсан иргэд хоол унд, нөхцөл байдлаа голж янз бүрийн авир гаргалаа гэж дуулдах юм. Үнэхээр эмнэлгээс өгч байгаа хоол хангалтгүй байна уу. Эсвэл тэр хүмүүс хэтэрхий цамаан зан гаргаад байна уу?

-Ихэнх нь эмнэлгийн дотоод журмыг сахиж, бидний тавьж буй шаардлагыг биелүүлж, ойлголцоод явдаг. Аюулт өвчин гарсан учраас 14 хоног тусгаарлагдахаас аргагүй гэдгээ ухамсарлаж, бидний ажлыг дэмждэг хүн олон бий. Гэхдээ уулын мод урттай, богинотой гэдэг шиг асуудлыг ойлгохгүй, уурлаж бухимдсан, "Намайг эрүүл байхад тусгаарлалаа" гэж уурлах хүн ганц нэг байна. Ийм хүмүүст бид аль болох нөхцөл байдлыг тайлбарлаж, ойлголцохыг хичээдэг. Учирлаад хэлэхээр хүмүүс ойлгодог юм аа.

-Одоо улс орны хэмжээнд хөл хорио хэвээр байна. Энэ хориог хэр удаан үргэлжлүүлэх ёстой вэ. Та мэргэжлийн хүний хувьд санал бодлоо хуваалцаач?

-Вирусийн халдварын нөхцөл байдлаас л хамаарна. Цаашдаа игэх ёстой, тэгэх ёстой гэж хэлэх боломжгүй шүү дээ. Ямар ч байсан дөрөвдүгээр сарын 30 хүртэл сургууль, цэцэрлэгийн хөл хориог сунгачихлаа. Энэ вирусийн халвар дэлхий нийтэд, манай улсад ямар байх вэ, өвчлөл нэмэгдэх үү гэх мэт нөхцөл байдлаас шалтгаалаад тухайн үед нь шийдвэр гаргах байх. Харин урьдчилан шийдвэр гаргах ямар ч боломжгүй. Тиймээс хүнд хэцүү энэ үед дэг журмаа алдалгүй, урьдчилан сэргийлэлтээ сулруулалгүй, хувийн ариун цэврээ сайн сахиж, мэргэжлийн байгууллагын шийдвэрийг ягштал биелүүлж чадвал бид халдварыг эрсдэл багатай даван туулна.

-Ярилцсанд баярлалаа. ■



SKY GARDEN

Дэлхийн барилга, архитектурын салбарт вертикал буюу босоо чиглэлд хөгжүүлсэн ногоон байгууламжийг Sky Garden хэмээн нэрийддэг. Өгөөд энэхүү шийдлийг төлөвлөлтөнд тусгаснаар өндөр түвшний барилгад байгалийн мэдрэмжийг бодитоор хүртэх боломжийг бүрдүүлсэн.

VERTICAL GARDEN • BOSCO

True Luxury ЗӨВ ТАНСАГЛАЛ



Сэтгэлд нийцэх "Байршил"

Ногоон бүсийн үнэ цэнэтэй байршил, 180-360 градус харах өнцөгтэй



Ирээдүйгээ хайрласан "Хүүхэд төвтэй төлөвлөлт"

Хүүхдийн эрүүл аюулгүй хөгжих орчин



Winter Garden Дөрвөн улирлын цэцэрлэг

4-н улирлын ногоон байгууламж



Аюулгүй байдлыг бүрэн хангасан "Дугуйн гүүрэн гарц"

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнтэй холбогдсон аюулгүй гарц



Рашаан түгээх системтэй

Дөрвөн улирлын турш гэртээ рашаанд орох боломж



Чанарын баталгааг амлах "Материалын сонголт"

Дэлхийн шилдэг чанартай материалаар брэнд орчинг цогцлоосон



Бүхнийг цогцлоосон "Sky Park Plaza"

Хүний бүх хэрэгцээг нэг дор цогцлоосон нэгдсэн үйлчилгээний төв



Газар доогуурх зам бүхий "Галерей"

Хотхоны бүх барилга болон үйлчилгээний төв газар доогуураа туннелээр холбогдсон

Sky Garden Residence...
Yet within, peace and calm prevails.



Борлуулалтын оффис | Sales Office
+ 976 771 55555

Борлуулалтын менежер | Sales manager
+ 976 8888 0835, 8888 0836, 8888 0837

skygarden.mn
info@skygarden.mn


Халуухан бүжигчин Б.Оюунтуяа

✍ Н.Сийлэн, ЗГМ сонин

Q.N belly dance хамтлагийн бүжигчин, make up artist Б.Оюунтуяаг энэ удаагийн “Гоо сайхан” буландаа онцолж байна. Тэрбээр фото моделийн чиглэлээр амжилт үзүүлж яваа чадварлаг бүсгүй бөгөөд тун удахгүй belly dance төвөө үүсгэн байгуулахаар ажиллаж буй. Үзэсгэлэнт бүжигчин бүсгүй маань гоо сайхны салбарт тэсрэлт хийх алсын зорилго өвөртөлсөн ажилсаг нэгэн бөгөөд бүх хувцас хэрэглэлээ өөрөө урладаг.


- Биеийн жин: 53 кг
- Биеийн өндөр: 168 см
- Биеийн харьцаа: 95:65:97 см
- Биеийн хамгийн дуртай хэсэг: Нүд
- Орд: Загас
- Төрсөн он, сар, өдөр: 1998.03.03
- Үсний өнгө: Хар
- Нүдний өнгө: Хар
- Төгссөн сургууль: Сургуулиасаа чөлөө авсан, гадаадад суралцахаар бэлтгэж байна
- Ажил: Belly dancer, Make up artist
- Мэргэжил: Жүжигчин, Make up artist
- Идэх дуртай хоол: Амттай бүх хоолонд дуртай
- Дуртай сүрчиг: Coco chanel
- Дуртай өнгө: Хар
- Хобби: Гоо сайхантай холбоотой бүх зүйлд хоббитой. Мөн сонирхолтой подкаст сонсох, тэмдэглэл хөтлөх, спортоор хичээллэх, аялах
- Зорилго: Одоохондоо нууцалж байна
- Дуртай брэнд: Sergio Rossi, Coach, Rolex, Bvlgari
- Баримталдаг зарчим: Эрүүл мэнд, ариун цэвэр хамгийн чухал
- Нууц авьяас: Гоо сайхны бүх зүйлээ өөрөө хийдэг. Үс, хумс, нүүр будах гэх мэт. Мөн бүжгийн бүх хувцасаа оёдог.
- Багын хоч: Алаг нүдэн
- Үзэх дуртай кино: Хөгжимт кино
- Хэлэх дуртай үг: Хүчтэй бай
- Өглөөг хэрхэн эхлүүлдэг вэ: Дуртай дуугаа сонсдог
- Утасны дэлгэцэн дээрх зураг: Зураг байхгүй
- Instagram хаяг: tuka_boldbaatar






PEN BOUTIQUE

2nd floor, Central tower, 2
Sukhbaatar square, khoroo 8,
Sukhbaatar district

 penboutiquemongolia

 penboutique.mn

 7000-9880

5 хүртэлх насныханд COVID-19 хамгийн хүнд тусна

Дархлаа нь бүрдэж гүйцээгүй нэг хүртэлх насныхан хамгийн их хүндэрч байв



Таваас доош насны хүүхдийн дархлаа сул, уушги бүрэн бэхжээгүй байдаг учир тэднийг эрсдэлтэй бүлэгт хамруулсан байна.

Америкийн анагаах ухааны холбооны сэтгүүлд Хятадын 72000 халдвар тээгчийн мэдээллийн нэгтгэсэн судалгааны дүнг нийтэлжээ. ДЭМБ-ын төлөөлөгчид Хятадад ирээд коронавирүсийн халдвар авагсдын 2.5 орчим хувь нь 18-аас доош насныхан байгааг мэдээлсэн. Гэхдээ уг тайланд “Хүүхдүүдийн дунд халдвар тархалтын түвшинг нарийн тооцоолох аргагүй. Түүнчлэн тэд вирус дамжуулахад ямар үүрэг гүйцэтгэдэг, шинж тэмдэг бага илэрдэг буюу өөр байдлаар илэрдэг зэргийг бүрэн судлаагүй байна” хэмээн онцолжээ.

Pediatrics сэтгүүлд гарсан сүүлийн судалгааны тайланд бичсэнээр хүүхдүүдийн олонх

нь COVID-19 өвчлөлийг хөнгөн давдаг ба халдвар авсан бага насныхны зургаа орчим хувьд нь хүндрэл гардаг аж. Өнөөгийн байдлаар шинэ коронавирүс хүүхдэд хэрхэн нөлөөлдөг талаар дараах дүгнэлтийг хийжээ.

COVID-19 өвчлөлийг үүсгэгч SARS-CoV-2 вирус нь хүүхэд ба томчуудыг өвчлүүлдэг. Хятадын Шэньжэн мужид вирус тархсан байдалд анализ хийгээд хүүхдийн халдвар авах магадлал томчуудынхтай адил гэж дүгнэв.

Коронавирүс тээгч хүүхдэд өвчлөлийн шинж тэмдэг насанд хүрэгчидтэй харьцуулахад бага илэрдэг аж.


Гэхдээ хүүхдийн нас багасах тусам эрсдэл нэмэгддэг байна. **Хятадын 2143 хүүхдэд хийсэн халдвар судлалын шинжилгээнээс үзэхэд тав хүртэлх насны хүүхдэд шинж тэмдэг хурц илэрч, амьсгалын хүндрэл үүсжээ.** Ялангуяа, дархлаа нь бүрдэж гүйцээгүй

ТАВААС ДООШ НАСНЫ ХҮҮХДИЙН ДАРХЛАА СУЛ, УУШГИ БҮРЭН БЭХЖЭЭГҮЙ БАЙДАГ УЧИР ТЭДНИЙГ ЭРСДЭЛТЭЙ БҮЛЭГТ ХАМРУУЛСАН.

нэг хүртэлх насныхан хамгийн их хүндэрч байв.

Энэ байдал Уханьд батлагдсан юм. Зарим урьдчилсан судалгаанаас үзэхэд **SARS-CoV-2 вирусийн шинж тэмдэг илрээгүй ч эхний хоёр долоо хоногтоо маш их халдвартай байдаг нь нотлогджээ. Энэ хугацаанд амьсгалын замын дээд хэсгийг бөглөрүүлж, ханиалгах, найтаах байдлаар халдана.** Үүнээс гадна хүүхдийн өтгөн наалдсан сандлаар ч халдвар дамжих боломжтой гэнэ.

Эрдэмтэд түүхэнд анх удаа хүний эсийг залуужууллаа



Стэнфордын их сургуулийн эрдэмтэд шинжлэх ухааны түүхэнд анх удаа хүний эсийг залуужуулж чадсан талаар Nature сэтгүүлд нийтлэгджээ. Эрдэмтэд үүдэл эс бүтдэг механизмыг ашиглан нээлтээ хийхдээ тусгай рибонуклины хүчлийг ашиглаж, эсүүдэд яманайн хүчин зүйлийг бий болгосон аж. Энэ нь эмбрионы эсүүдийг бүтээхэд чухал үүрэг гүйцэтгэдэг тусгай уураг бүтэх үйл явц юм. Хэрэв энэ механизмыг энгийн эсүүдэд хоёр долоо хоногийн турш явуулбал iPSC хэмээх үүдэл эс үүсдэг байна.

Эрдэмтэд уг эсээс хөгшрөлтөөр үүсдэг сөрөг хүчин зүйлсийг арилгахын тулд хэдэн өдрийн турш дээрх аргыг хэрэглэхэд туршилтын явцад **эсүүд үнэхээр залуужиж, олон шинж чанараараа залуу эсүүдээс ялгарахааргүй болсон байна. Юуны өмнө эсүүдийн гадаад зураглал өөрчлөгдсөн аж.** Хүний ДНХ-ийн хамгийн хөнөөлтэй хэсэг нь залуу байхад хязгаарлах системд хоригдож байдаг бол хүн хөгшрөх тусам уг систем сулардаг гэнэ. Яманайн хүчин зүйлийг ашигласнаар уг системийн сулрах үйл явцыг

Коронавирүс тусвал үнэрлэх чадваргүй болдог шинж илэрнэ



Сүүлийн судалгаанд дурдсанаар коронавирүс халдварласан хүнд илэрдэг нэг нууц шинж тэмдэг нь үнэрлэх чадвараа алдах явдал юм байна.

Today News Ufa сайтад мэдээлсэнээс үзвэл Австралийн Флиндерсийн их сургуулийн эрдэмтэд коронавирүсийн халдвар авсан боловч шинж тэмдэг нь хурц илрээгүй хүмүүсийн дунд судалгаа явуулаад бараг бүх хүн үнэрлэх мэдрэхүйгээ алдаж буйг илрүүлсэн байна. Энэхүү нийтлэг шинж тэмдэг SARS-CoV-2 вирусийн халдвар авсан хүмүүсийн хамрын салслаг эд хөөдгөөс үүдэлтэйг эрдэмтэд тогтоов.

Одоо уг шинж тэмдгийг

коронавирүс “нууцаар” тээгчдийг илрүүлэхэд ашиглаж болох юм. Дэлхий даяар COVID-19 ийм түргэн тархаж байгаа нь юуны өмнө иймэрхүү үл үзэгдэх шинж тэмдгээс шалтгаалсан гэж тооцов. **Үүгээр зогсохгүй үнэрлэх чадвараа алдах нь урт хугацаанд халдвар авсныг тодорхойлох цорын ганц шинж тэмдэг байж болзошгүй юм.** Өмнөд Австралийн эмч нар нийт өвчлөгсдийн гуравны нэг нь үнэрлэх чадвараа алдаж байгааг ажиглажээ. Британийн халдвар судлаачид аносми буюу үнэрлэх эрхтний гэмтлийг цаашид коронавирүсээр өвчлөгсдийн үндсэн шинж тэмдэгт багтаах бодолтой байна. ■

ХҮҮХДЭЭ ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨГӨӨ

Pediatrics сэтгүүлд нийтэлсэн өгүүллийн нэг зохиогч, Виржинийн их сургуулийн хүүхдийн халдварт өвчний хэсгийн удирдагч Стивен Зейхнерийн бичжээ. Тэрбээр “Халдвар авсан олонх хүүхдэд шинж тэмдэг илэрдэггүй буюу бага илэрдэг учир нийгмийн зай барих дэглэм, ариун цэвэр болон урьдчилан сэргийлэх бусад арга хэмжээг сахих ёстой. Гэр бүлийн гишүүд, ялангуяа өвчин хуучтай эмээ, өвөө нарт хамгийн их эрсдэл ирдэг” хэмээн тодорхойлжээ. Эрдэмтний хэлснээр эцэг, эхчүүд өөрөөсөө “Би коронавирүсийн тархалтаас сэргийлэхийн тулд бүгдийг зөв хийж байгаа юу?” гэж асуугаад цаашид юу хийхээ тодотгох ёстой юм.

1. Бусад хүүхэдтэй тоглох, үдэшлэг хийх, найз нөхөдтэйгээ хамт хооллохоос бүрэн татгалзах. Айлд зочлохгүй, хүн урихгүй байх. Нийгмийн зай барих дэглэмийг дагаж мөрдөх.
2. Хүүхдээ бусадтай хамт зугалаахыг үл зөвшөөрөх. Ганцаараа гадаа тоглох нь ч бас эрсдэлтэй. Вирус ямар ч гадаргуу дээр 48 цаг амьдрах чадвартай. Тиймээ дугуйгаар аялах нь арай аюулгүй.
3. Хүүхдийн гарыг өдөрт хэдэн удаа угааж, нүүрэндээ гараа хүргэхгүй байхыг байнга сануулах.
4. Хүүхдийн хувцас, тоглоомыг аль болох олон удаа угааж цэвэрлэх.
5. Хэн нэгнээр хүүхдээ харуулахгүй байх. Ялангуяа, эрсдэлтэй бүлэгт багтдаг эмээ, өвөө нарт нь орхихоос зайлсхийх.
6. Хэрэв хүүхэд өвдсөн бол эмнэлэгт аваачилгүй гэртээ асарсан нь дээр. COVID-19 өвчний шинж тэмдэг илрээгүй бол сорилт хийх шаардлагагүй ба харин эмнэлэгт халдвар авах эрсдэл маш өндөр. ■

ZGM DAILY

⊕ One more COVID-19 case recorded, totaling 11

According to the Director of the National Center of Communicable Diseases (NCCD), 221 passengers were aboard and the government arranged charter flights.

⊕ ADB to grant USD 1 million to spur Mongolia's fight against COVID-19

The grant, from the Asia Pacific Disaster Response Fund, will fund the immediate purchase of key medical equipment.

World Bank: 15% of the population is just above the poverty line

National poverty rate of Mongolia fell slightly to 28.4 percent in 2018



⊕ Less-inclusive consumption growth in urban areas was accompanied by stagnation in poverty, leaving the poverty rate unchanged at 27 percent from 2016 to 2018.

Image by Batsaikhan.S

✍ Amina.U, ZGM Daily

According to the National Statistics Office (NSO), the national poverty rate of Mongolia fell slightly from 29.6 percent in 2016 to 28.4 percent in 2018. As much as 15 percent of the total population is clustered just above the national poverty line, risking to slip into poverty in an event of any unanticipated

shocks, the report released by the World Bank highlighted.

The new joint report by NSO and the World Bank, "Mongolia Poverty Update", provides the latest analysis on poverty trends and people's profiles in Mongolia based on the 2018 Household Socio-Economic Survey.

Despite robust economic growth, Mongolia is struggling to translate the benefits of growth into household-level welfare, especially for the

poor. Many of the poor, in particular low-skilled wage workers, are missing out on the benefits from the recent capital-intensive mining sector-led growth.

Between 2016 and 2018, poverty reduction was uneven, declining in rural but not in urban areas. Growth in rural areas was faster and favorable to the poor, contributing to reducing rural poverty by 4 percentage points from 34.9 percent in 2016 to 30.8 percent in

2018. By contrast, less-inclusive consumption growth in urban areas was accompanied by stagnation in poverty, leaving the poverty rate unchanged at 27 percent from 2016 to 2018. The lack of progress in poverty reduction in urban areas was mainly driven by stagnant wage growth in the poorest population group, while strong growth in farm income supported by rising livestock prices, together with the expansion of poverty-targeted so-

cial protection programs, contributed to robust poverty reduction in rural areas.

Consequently, poverty is increasingly concentrated in urban areas. Although the incidence of poverty is still higher in rural areas (30.8 percent) than in urban areas (27.2 percent), with two-thirds of the population living in urban areas, more than six out of ten poor people now live in urban areas. ■

COMMODITY MARKET

✍ Bayartsetseg.D, ZGM Daily

Copper is one of the crucial mineral products which defines its falls and rises of Mongolia's economy, however, the price has been decreasing since January. As included in the 2020 State Budget, officials are expecting to benefit MNT 1.1 trillion from copper export, estimating the price at USD 5,991 per ton but the metal has been continuing to decline in previous weeks.

In 2019, the copper price

reached USD 6,250 per ton and it fell dramatically by 25 percent from earlier months. According to the analysts, the copper price may fluctuate between USD 4,500-5,000 during the period. Economist Mr. Enkhbayar said, "Global economy is deteriorating due to COVID-2019 spread, and metals, specifically copper price has been plunging in the commodity market. Additionally, Mongolia's total revenue from copper concentrate export is likely to drop

by 15-20 percent in line with price fluctuation. There is a risk that the budget revenue might be cut with a deficit of MNT two trillion so that officials are required to make budget amendments."

Moreover, budget revenue in 2020 expected to be around MNT 11.7 trillion and expenditures MNT 13.7 trillion. However, the foreign trade surplus decreased 10 times from a year ago. According to the National Bureau of Statistics of China, the Primary industry declined by



13.5 percent and investment had shrunk by 24.5 percent. For Mon-

golia, budget revenue is likely to cut off due to China's economic crisis. ■

ZGM: HIGHLIGHTS

■ **POLITICS**


The President of Mongolia Battulga Khaltmaa calls on the government to amend the state budget, cut all election expenses, and use the proceeds for anti-crisis measures.

The Parliament Speaker Zandanshatar Gombojav decides to hold the regular spring session of Parliament online due to the global epidemic of COVID-19 and the high level of preparedness in Mongolia. Preparations for the online meeting have begun at the Secretariat of the Parliament.

■ **ECONOMY**

The Government plans to receive USD 26.9 million in financial support from international organizations to prevent and respond to COVID-19. In particular, it intends to attract funding for the supply of essential medical equipment. It will receive a USD 13.1 million soft loans from the International Development Association and sign a USD 13.8 million loan agreement with the IBRD.

Top 20 index drops 1.12 percent, to 17,222.52 points. MSE A index 0.88 percent, to 7,999.65 points. MSE B index decreases 0.07 percent to 7,594.43 points. Market cap stands at 2.48 trillion.



The Financial Regulatory Commission (FRC) decides to postpone the payment regulatory services from non-bank financial institutions, savings and credit cooperatives.

■ **SOCIETY**

Mongolia is to repatriate its 751 nationals to their home country through three time-evacuation flights in the near future. Specifically, a chartered flight will be operated to Seoul at 8 am of April 2, to Tokyo at 01:30 am of April 3 and to Seoul at 8:30 am of April 4 respectively. Citizens, who will arrive on the aforementioned charter flights, will stay in quarantine for 21 days at least.

SOCIETY

One more COVID-19 case recorded, totaling 11



✍️ Tenuun.A, ZGM Daily

On Thursday, a new positive case of COVID-19 has confirmed in Mongolia, reaching the total number to 11. A person who tested positive is now staying under mandatory isolation after arrived in Mongolia on a charter flight from Istanbul Turkey last week.

According to the Director of the National Center of Communicable Diseases (NCCD) Mr. Nyamkhuu, 221 passengers were aboard and the government arranged charter flights. All of them went under testing for coronavirus and one person

A person who tested positive is now staying under mandatory isolation after arrived in Mongolia on a charter flight from Istanbul Turkey last week.

has been confirmed to be infected with the coronavirus. **In addition, random samples taken from 25 people who are being treated at local hospitals for disease, tested all negative.**

On March 25, one suspected case had been isolated and 184 people are being monitored under isolation at the NCCD. There are 7 people working in the medical group including a doctor, nurse, medic and attendant. He also mentioned that **MNT 800,000 is being spent on each coronavirus patient, containing costs for protective equipment for the healthcare team members.** ■

FOREIGN TRADE

✍️ Bayartsetseg.D, ZGM Daily

As of February 2020, Mongolia accounts for 19 percent of China's coking coal imports. The country comprised 92.3 percent of its southern neighbor's coking coal

imports in 2019. In addition, Australia's coking coal export to China has increased and it made up 74 percent of China's imports in the first two months of this year.

In January and February, China imported 10.4 million tons of

coking coal from Australia and 2.7 million tons from Mongolia. In the same period of the previous year, Australia exported 5.5 million tons to China and Mongolia 3.5 million tons. In other words, coking coal exported from Mon-

golia to China decreased.

In the first two months of this year, China imported a total of 68.1 million tons of coking coal and other types of coal, up 33 percent from the yoy. ■

ADB to grant USD 1 million to spur Mongolia's fight against COVID-19

The Asian Development Bank (ADB) yesterday approved a USD one million grant to support the Mongolian government's fight against the novel coronavirus (COVID-19) pandemic.

The grant, from the Asia Pacific Disaster Response Fund, will fund the immediate purchase of key medical equipment, such as diagnostic and emergency medical equipment, and supplies for personal protection.

"ADB is committed to supporting Mongolia in the fight to prevent the spread of COVID-19. This assistance will support the government as it procures high priority equipment to address a situation that poses the potential for a prolonged public health threat in the country," said ADB Director General for East Asia James Lynch.

As the virus continues to spread globally, the government has assigned the highest possible risk rating to the emergency under the Law on Disaster Protection, and allocated USD 4.3 million from the state budget to respond to urgent needs.

It is still wintertime in Mongolia with temperatures well below freezing and this is a time of high risk for the seasonal flu. Respiratory diseases make up a high proportion of the burden of disease in Mongolia and the Ministry of Health has identified 20 percent of the population at high risk.

The assistance follows ADB's announcement on 18 March of the reallocation of USD 1.4 million from the Fifth Health Sector Development Project in Mongolia to procure essential medical equipment for early detection, emergency care, and management of severe respiratory diseases. ADB also approved a USD 225,000 small-scale technical assistance to strengthen Mongolia's national capacity for infection prevention and control. ■

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020.03.27

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Компрессорын удирдлагын самбар тоноглол нийлүүлэгчийг сонгон шалгаруулах .
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР/ГЭРЭЭНИЙ ДУГААР: УСУГ-ХА-2020-61
 Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендерт оролцогчдоос Компрессорын удирдлагын самбар тоноглол нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна. Тухайн тендерт эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 /тавин мянган/ төгрөгний цахим тендерийн хураамж төлж оролцоно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.
 Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.
 Үүнд:
 • Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.
 • Сүүлийн 2 жилд буюу 2018, 2019 он тус бүрд бараа нийлүүлсэн тухай мэдээлэл ирүүлнэ.

• Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил буюу 2018, 2019 он тус бүр төсөвт өртгийн 100 хувиас дээш байх.
 • Тендерийн хамт 1,200,000 /нэг сая хоёр зуун мянган /төгрөгний тендерийн баталгаа тус ирүүлнэ.
 • Хүчинтэй байх хугацаа: 2020 оны 6 дугаар сарын 27-ны өдрийг дуустал.
 Тендерийг 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө цахим системээр тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 10 цаг 30 минут-аас нээнэ. Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. Дотоодын давуу эрх тооцохгүй.
 Гадаадын этгээд оролцох эрхгүй.
 Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5, өөрийн байр, Б.Лхагвасүрэн
 Утас: 70157018-123



Хакерууд халдлагыг хуурамч имэйл илгээх, эсвэл таны хувийн мэдээллийг цуглуулах зорилгоор тусгайлан хийсэн вэб сайт руу хөтөлж оруулах замаар үйлддэг. Вэб сайт руу хөтөлж зорилгоор ирсэн имэйл ихэвчлэн таны хувийн мэдээллийг шаарддаг.



Мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах алхмууд

Компьютерт халдварласан хорлонт код товчлуурын дарсан товч бүрийг хакер руу дамжуулдаг

Б.Гантиг, ЗГМ сонин

Хэрэглэгчийн аюулгүй байдлын чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг Английн BullGuard компани фишингээс сэргийлэх зөвлөгөө гаргажээ. Уг зөвлөгөөг хүргэж байна.

Фишинг гэдэг нь хувийн мэдээллийг хулгайлах зорилготой үйлдлүүдийн нэг юм. Энэ нь ихэвчлэн таны хувийн мэдээлэл, голдуу нууц үг, банкны мэдээлэл, түүн дотроо кредит болон дебит картны чинь нарийн мэдээллүүдийг авах зорилготой занга аж. Хакерууд хуурамч имэйл илгээх, эсвэл таны хувийн мэдээллийг цуглуулах зорилгоор тусгайлан хийсэн вэб сайт руу хөтөлж оруулах замаар үйлддэг. Таныг вэб сайт руу хөтөлж зорилгоор ирсэн имэйл ихэвчлэн таны хувийн мэдээллийг шаарддаг. Хэрвээ энэ тохиолдолд мэдээллээ оруулвал таны мэдээлэл хакеруудад очих бөгөөд тэд мэдээллийг чинь ашиглан таны банкны, нийгмийн сүлжээний болон бусад системд нэвтрэх оролдлого хийдэг. Зарим фишингийн вэб сайтууд хууль ёсны вэб сайтуудыг дуурайлган хийсэн байдаг. Тухайлбал, PayPal, Yahoo, eBay гэх мэт.



1 АЖИЛТНУУДАА АНХААРУУЛАХ МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ

Фишингийн төрлийн имэйлийг таньж болдог. Учир нь тэд нууц үг, дансны болон бусад нарийн мэдээллийг асуудаг. Зарим имэйл нууц мэдээлэл авах форм агуулсан байдаг. Энэ форм нь таныг нэр, хаяг, банкны мэдээллээ оруулахыг хүсдэг. Хакерууд таны оруулсан мэдээлэл бүрийг ашиглан дараагийн үйлдлээ хэрэгжүүлдэг. Хэрвээ та өөрөө л хүсэлт гаргаагүй бол ихэнх хууль ёсны банкууд болон бусад байгууллагууд иймэрхүү төрлийн мэдээлэл авах зорилготой имэйлийг хэрэглэгчдээ илгээдэггүй гэдгийг санах хэрэгтэй.



2 ХУУРАМЧ УРАМШУУЛАЛ
Танд ямар нэгэн урамшуулал зарлагдсан гэх имэйл ирнэ. Хэр-

вээ таны үйлчлүүлдэг банкнаас ямар нэгэн урамшууллын мэдээлэл ирвэл ядаж нэр эсвэл дансны дугаарыг чинь дурдсан байдаг. Харин фишинг нь маш ерөнхий байдаг. Зарим урамшуулалтай холбоотой фишингийн имэйл таны урьд өмнө хэзээ ч харилцаж байгаагүй санхүүгийн байгууллагаас ч ирж болно.



3 ЯНЗ БҮРИЙН СҮРДҮҮЛГЭЭС АЙХГҮЙ БАЙХ

Фишинг ихэвчлэн ховор тактик ашигладаг. Хэрвээ та тэдний хүссэн үйлдэл (тухайлбал, төлбөрийн мэдээллээ өгөх эсвэл мэдээлэл шинэчлэх гэх мэт)-ийг хийхгүй бол үйлчилгээг зогсоох эсвэл бүртгэлийг чинь хүчингүй болгох тухай имэйл байнга илгээнэ. Хэрвээ таны мэдэх ямар нэгэн нэг байгууллагаас иймэрхүү төрлийн имэйл ирвэл үйлдэл хийхгүйгээр эхлээд тухайн байгууллагад хандаж асууж, лавла. Практикт хууль ёсны байгууллагууд иймэрхүү төрлийн дайралтын аргыг хэрэглэгчдэдээ ашигладаггүй аж. Ихэнх компани хянуур

болгоомжтой байдаг бөгөөд ихэвчлэн эмзэг мэдээллийг хэрэглэгчдээсээ шаарддаггүй.



4 АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ПРОГРАММ СУУЛГАХ


Эцэст нь хэлэхэд хамгийн найдвартай арга бол компьютертээ аюулгүй байдлын сайн программ суулгах. Энэхүү төрлийн программууд имэйл дэх хуурамч холбоосыг илрүүлэх, мөн автоматаар хуурамч вэб сайтуудыг илрүүлэх, блоклох үйлдлийг хийж чаддаг. Мөн эдгээр программууд томоохон банк болон худалдааны вэб сайтуудын жинхэнэ эсэхийг танд баталгаажуулж өгдөг.



5 ҮНЭГҮЙ ЗҮЙЛД ТАТАГДАХ ХЭРЭГҮЙ

Ихэнх фишингийн занга нь үнэгүй зүйл өгөх мэтээр имэйл

илгээдэг. Энэ тохиолдолд та зүгээр л дээрх зүйлсийг хожихын тулд холбогдох холбоос линкээр дамжин вэб сайт руу хандаж, өөрийн мэдээллээ оруулах хэрэгтэй. Эдгээр төрлийн вэб сайт хорлонтой кодтой байдаг бөгөөд хэрвээ тус вэб сайтад зочилбол таны компьютерт халдварласан хорлонт код товчлуурын дээр дарсан товч бүрийг хакер руу дамжуулна.



6 POP-UP ЦОНХНООС БОЛГООМЖЛОХ

Интернэт браузерийн дээд хэсэгт зарим тохиолдолд нэг цонх доош гарч ирэн зарим нэг үйлдэл хийхийг шаарддаг гэдгийг та бүгд мэднэ. Pop-up цонхийг фишингт ашиглах тохиолдолд эдгээр цонх таны компьютерт хорлонтой код суусан байна, та үүнийгээ засахын тулд засагч (security fix) татах хэрэгтэй гэх мэтээр байнга гарч ирдэг. Хэрвээ тэр засах товч дээр та дарвал өөрийн компьютертээ янз бүрийн хорлонтой код суух боломжийг олгох юм. Тиймээс зүгээр л pop-up цонхийг шууд унтраах хэрэгтэй. ■

ЭНЭ ӨДРИЙН ЗУРХАЙ

Арслангийн ордынхон мөнгөний асуудлаас болж шанална



Хонь /III.21-IV.19/

Таны хийж байгаа зүйл ойр дотнын хүмүүсийн тань санаанд нийцэхгүй, таныг дэмжихгүй байгаагаас болж тэдэнтэй харилцаагаа хурцатгахгүй байхыг анхааруулж байна. Нэмэлт зарлага гарах учраас үүнийг эртнээс тооцоолох хэрэгтэй. Гэр бүлийнхээ орлого зарлага, санхүүдээ анхаарлаа хандуул. Өнөөдрийн ажлын гүйцэтгэлээ хийж чадахгүйд хүрч мэднэ.



Мэлхий /VI.22-VII.22/

Ямар нэгэн шинэ ажлыг эхлүүлэх, төлөвлөгөө зохиох, хуучин ажилтай холбоотой бичиг баримтыг цэгцлэхэд бүхий л анхаарлаа хандуулах болно. Ганц бие хүмүүсийн хувьд шинэ хүнтэй танилцваас удаан хугацаанд үргэлжлэх нөхөрлөл болно. Аливаа асуудлын араас хэт улайран хөөцөлдөх хэрэггүй.



Жинлүүр /IX.23-X.22/

Таны дэргэд нөлөө бүхий нэгэн хүн гарч ирнэ. Энэ нь хувийн амьдралтай хамаагүй юм. Таны шулуун шударга, хичээнгүй зан тань цаашдын ажил хэргээ амжилттай өрнүүлэхэд ихээхэн тус болно. Ямар нэгэн хэлэлцүүлэгт оролцох, цайллага дайллагад явах, чухал асуудал шийдвэрлэх зэрэгт хэт догдолж хэрэггүй.



Матар /XII.22-I.19/

Өнөөдөр гэр бүлийн тань хүн хийхээр төлөвлөсөн ажлаа амжилттай дуусгаж танд баярт мэдээ авчрах болно. Таны сэтгэл хөдлөл нэлээд өндөр байх болно. Хувийн амьдралд урам хугарах, гомдол зэмлэл байх ч тэднийг үлдэн хөөж чадна. Ажил хэргийн амлалтаа ч биелүүлж, төлөвлөгөө дуусгана. Ачаалалтай ажлын дараа найз нартайгаа ярьж суух, ганц нэг пиво уухыг хүснэ.



Үхэр /IV.20-V.20/

Оюун санааны хувьд хувьд гэгээрлийг олох, зоригтой алхмуудыг хийх, хэн нэгэнд амлалт өгөхөд таатай. Уран бүтээлчдийн хувьд бодсон санасан шиг амжилттай байж чадахгүй нь бололтой. Та өөрийгөө хэтэрхий их хүчилснээс эргээд урам хугарахад хүрнэ. Эрчүүдийн эрүүл мэнд таагүй байна. Ялангуяа, сэтгэл санаа тогтворгүй хүмүүст илүү ихээр хамааралтай.



Арслан /VII.23-VIII.22/

Маш их дарамт шахалт дор ажил үйлчилгээгээ явуулах шаардлага тулгарна. Энэ танаас шалтгаалах зүйл биш тул та нөхцөл байдлыг тайвнаар ажигла. Зарим нэг нь маш их хэмжээний мөнгөний асуудалд орж түүнээс гэрч чадахгүй шанална. Энэ байдал нэлээд удаан хугацааны турш үргэлжилж магадгүй.



Хилэнц /X.23-XI.22/

Өнөөдөр танд ажил хэргийн таатай санал ирж магадгүй. Гэсэн хэдий ч төлөвлөсөн ажлаа хойш тавих хэрэггүй. Удирдлагатайгаа илэн далангүй, нээлттэй санал бодлоо солилцож чадна. Онцын шаардлагагүй бол мөнгө төгрөгт үрэлгэн хандах хэрэггүй. Хуучны хамтрагч тань таныг дурсаж, эрэн хайх болно. Та түүний хувьд дахин хамтрахад таатай нэгэн нь байх болно.



Хумх /I.20-II.18/

Ажил дээрх зарим харилцаа төвөгтэй санагдаж, өөр шинэ орон зайд, шинэ энерги мэдрэхийг хүснэ. Энэ нь хамт ажиллах хүний таагүй энерги, дээрэнгүй зангаас болж мэднэ. Ойрын хүнээс хууралт мэдрэх тул маш хүндээр тусч та өөрийгөө буруушаана. Цаг хугацааны л асуудал тул хэт их сэтгэлээр уналгүй, нөхцөл байдлыг тайвнаар шийдвэрлэ. Аливаа худалдан авалтдаа анхаар.



Хамтатгах /V.21-VI.21/

Таныг өнөөдөр эерэг сайхан зүйлс хүлээж байна. Энэ нь бүсгүйчүүдийн хувьд илүү тохиолдоно. Гоо үзэсгэлэнгээрээ та олон зүйлийг нааштай, эерэг болгож, бусдад сайн сайхныг бэлэглэж чадна. Мөн тэд өөрийн хүссэн зүйлийг авахыг эрмэлзэнэ. Танд тулгарсан асуудалд хөнгөн хуумгай хандах гэсний хэрэггүй. Их бага аль нь ч бай нухацтай бодож шийдвэрлээрэй.



Охин /VIII.23-IX.22/

Шударга ёс, дэг журмыг эрхэмлэнэ. Өнөөдөр танилцсан хүнтэйгээ яриа нийлж, олон зүйлийн талаар ярих ч биеэ авч явах байдал нь танд огтхон ч таалагдахгүй. Эсрэг хүйсний хүнтэй харилцахдаа хэт баригдмал, дүр эсгэх хэрэггүй. Өнөөдрийн ажил тань төлөвлөсний дагуу явагдаж чадахгүйгээс болж таны ажил нилээд оройтох бололтой.



Нум /XI.22-XII.21/

Та тооцоолоогүй зарлага гаргахаас зайлсхий. Өөрийн санхүүгээ эргэн хараарай. Танилцаад удаагүй танил тань хамтран ажиллахад таатай, танд ихээхэн тус дэм болно. Таныг мэхэлсэн, итгэл даагаагүй хүмүүсээс зайгаа барьсан нь дээр. Өнөөдөр гаргасан шийдвэр ойр тойрны хүмүүст гайхалтай бахархал төрүүлэх болно.



Загас /II.19-III.20/

Бага зэргийн үл ойлголцлыг эс тооцвол ерөнхийдөө тайван өнгөрөх болно. Санхүүгийн хувьд гэнэтийн зардал гарснаас жаахан хүндрэл учирна. Үүнээс үүдэлтэй та санхүүгийн тооцоогоо эргэн харна. Ашиггүй, санаанд нийцэхгүй ажилд заавал хамтрах гэж зүтгэх хэрэггүй. Төвөгтэй бодол санаагаар тархиа дүүргэх хэрэггүй.

ДОРНЫН ЗУРХАЙ

Дашнямтай өдөр




Аргын тооллын гуравдугаар сарын 27, Сугар гараг. Билгийн тооллын 3, хаврын дунд шарагчин туулай сарын найман цагаан мэнгэтэй, гоё хүүхэн одтой, шарагчин могой өдөр.

Үс засуулвал: Эд мал баялаг төгөлдөр болно.
Наран ургах, шингэх: 06:40-19:15 цаг
Барилдлага: Түлэх
Шүтэн барилдлага: Төрөн түгэхүй
Суудал: Шороо

Өдрийн наран 06:40 цагт мандаж, 19:15 цагт жаргана. Тухайн өдөр үхэр, тахиа жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба сан тавиулах, угаал үйлдэх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, буг дарах, газрын ам бооход сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, сэтгэлд сэвтэй газар очих, байшингийн суурь тавихад муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Дашнямтай өдөр.

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



ХӨНДЛӨНГӨӨР:

- 2. Эрчим хүчний үндсэн эх үүсвэр, гол түүхий эд
- 5. “Аладдины шидэт дэнлүү” үлгэрийн сармагчны нэр
- 7. Дэлхийн II дайнд хамгийн их хэрэглэгдсэн авто машин
- 9. 2.54 см хэмжээтэй тэнцэх хэмжилтийн нэгж
- 10. МСҮТ-ийн хуучин нэр (товчилсон)
- 11. Гэр
- 12. Хавтгайдуу ёроолтой модон аяга
- 13. Сэржим өргөдөг хуруу
- 14. Дэлхийн бүх цаг үеийн хамгийн алдартай домогт жанжин, Чингис хааны 9 өрлөгийн нэг
- 15. Гуалин банз бэлтгэдэг гол түүхий эд, мөнх ногоон мод
- 16. Хувхай зэвхий саарал

БОСООГООР:

- 1. MCS группийн бүрэлдэхүүнд багтсан шингэн хүнсний анхны үйлдвэрүүдийн нэг (товчилсон нэр)
- 3. Хуурай газрын хамгийн хурдан амьтан
- 4. Бодисын нэгэн төлөв
- 5. Монголын анхны хувийн нэгдсэн эмнэлэг
- 6. Багтаамж багатай
- 7. Монгол үндэсний бөхийн өмсгөл
- 8. Хуш модны боргоцой

ТАШУУГААР:

- 1. Алтайн нуруунд орших төрийн тахилгат хайрхан
- 4. Хүрд гэсэн утгатай төвөд нэр



Өмнөх дугаарын хариу 03.26

Г	А	Н	Х	У	Я	Г	З	Х	
А	■	А	■	Я	■	У	Б	У	
Н	А	Й	Д	А	Н	Д	О	Р	Ж
■	■	■	■	■	■	■	■	■	■
■	■	■	■	■	■	■	■	■	■
М	■	М	У	Л	С	■	■	М	А
■	■	■	■	■	■	■	■	■	■
■	■	■	■	■	■	■	■	■	■
■	■	■	■	■	■	■	■	■	■
Д	А	Р	А	М	С	Ү	Р	Э	Н

ЗГМ: СУДОКУ

3	7		6						
			7	1					
6			4	9	5				
	7	9			6		8		
	4	7	5						
			2			4			
		8	3						
7	1								
							6	4	

Өмнөх дугаарын хариу

3	9	5	6	2	7	1	8	4
8	1	6	5	4	9	2	3	7
4	2	7	1	3	8	9	6	5
2	8	4	9	7	3	5	1	6
7	6	3	8	5	1	4	9	2
1	5	9	4	6	2	3	7	8
9	3	2	7	8	4	6	5	1
6	4	8	3	1	5	7	2	9
5	7	1	2	9	6	8	4	3

Монголын хамгийн, хамгийн...

Монголчууд эх орныхоо “Хамгийн, хамгийн” гэх тодотголтой зүйлүүдийг бага сага мэддэг. Тухайлбал, хамгийн өндөр хүн-“Их

Монгол” Шаравжамц, хамгийн урт-Орвог гашууны бор толгой, хамгийн богино нэртэй гол-Эг гэх мэтээр хөвөрнө. Тэгвэл энэ удаа мэддэг мэт атлаа мэддэггүй “Хамгийн хамгийн”-ыг танилцуулъя.



Хамгийн өвөрмөц, үнэтэй хосгүй ном

Манай монголчуудын оюун билгээр урлаж бүтээсэн олон гайхамшигт бүтээлийн нэг нь “Сундуйн жүд” хэмээх ном юм. “Сундуйн жүд” буюу “Нууцын хураангуй” хэмээх энэ номыг XX зууны эхээр алдарт уран дархан

Дагва тэргүүтэй урчууд Төв аймагт байдаг Манзуширын хийдэд урлажээ. Уг номыг хийхдээ цаас ашиглаагүй бөгөөд зөвхөн мөнгөөр давтаж хийсэн гэдэг. Нимгэн мөнгөн хуудастай ба номын үсгийг алтаар цутгаж шаржээ. Энэ нь 10 боть

бүхий төвөд, хятад, монгол хадмал судар юм. Боть бүрийн эхний болон төгсгөлийн үг, зарим бурхан суваргын зургийг цэвэр алтаар урлаж, шүр сувдаар чимэглэн хийжээ. “Сундуйн жүд”-ийг бүтээхэд 52 кг алт, 400 кг мөнгө орсон.

Хамгийн сонин мөндөр

1936 оны намар Хэнтий аймгийн Баян-Өндөр сумын Боомтын амнаас Сухайтын шил хүртэл 5-6 километр урт, 400-500 метр орчим өргөн зурвас газар “зядь” хэлбэрийн улаан мөсөн мөндөр оржээ. Мөн 1973 онд Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутаг Шаргал нуурт Самрын боргоцой шиг арзгар гадаргуутай мөндөр орсон нь хамгийн сониноор бүртгэгджээ.



Монголын төдийгүй дэлхийн хамгийн том Ургийн бичиг

1905 онд бүтээгдсэн Цэцэн хан Шолойн ургийн бичигт 1577-1905 он хүртэлх 328 жилийн дотор төрсөн 11966 хүний нэрийг 5.3 метр голчтой даавуун дээр цагираглуулан бичсэнээрээ дэлхийн түүхэнд тэмдэглэгджээ. Энэ угийн бичиг одоо Үндэсний түүхийн архивт хадагалагддаг.



Хамгийн хүчтэй салхи

1975 оны долдугаар сарын 13-нд Ховд аймгийн Алтай суманд Агт уулын ард салхи 7-10 метр өргөн, 1200 метр урт зурвас газрын модыг үндсээр нь булгалж, ёзоороор нь хугалан

сүйтгэжээ. Мөн Ховдын Алтайд гарсан салхинд 115 айлын гэрээс 97 нь унасан баримт бий. Өнөөдрийг хүртэл хамгийн хүчтэй салхиарт бүртгэгдсэн хэвээр байна.



Үлэг гүрвэлийн хамгийн олон өндөгтэй газар

Дэлхийд хамгийн олон үлэг гүрвэлийн өндөг олдсон орд бол Өмнөговь аймгийн Гурвантэс, Булган сумын нутагт орших Баянзаг, Олгой, Улаанцав, Бугуйн цав зэрэг газар. Эдгээр газраас бараг гэмтээгүй 10-15 см урт чулуужсан өндөг хэдэн зуугаараа олджээ. Тэндээс олдсон чулуун өндөг эдүгээ Улаанбаатар, Москва, Варшав, Нью-Йоркийн музейд байдаг.

КИНО ЕРТӨНЦ

Коронавирусийн тахлаар олон ангит кино хийнэ

Дэлхийн 200 орчим оронд тархаад буй коронавирусийн тахлын оргил үеийг хятадууд даван гарч, хэвийн амьдралдаа шилжиж эхэлсэн. Хойд Америк, Европын топ спортын тэмцээн, олимп хүртэл коронавирусийн улмаас хойшилсон бол Хятадын сагсан бөмбөг, хөлбөмбөгийн лиг ирэх сараас эхлэх гэнэ. Тэр ч бүү хэл, коронавирусийн тахлын аюултай хэрхэн тэмцсэн талаар олон ангит кино хийхээр болжээ. Хятадын Үндэсний радио, телевизийн удирдлагын газрын хийх уг киног “Хамтдаа” гэж нэрлэсэн бөгөөд аравдугаар сараас дэлгэцээр гарах аж. 20 ангит тус кинонд нийгмийн бүхий л давхаргынхан халдварт өвчний эсрэг гар нийлэн ажилласан баатарлаг явдлыг харуулах юм байна. Бодит хүмүүсийн түүхийг бага зэрэг уран сайхны арга хэрэглэн үзүүлэх гэнэ. Найруулагч Чжан Синь “Энэ төслөөр би коронавирусийн эсрэг тэмцэлд өөрийн хувь нэмрээ оруулж байгаа юм. COVID-19 вирустэй тэргүүн эгнээнд тэмцсэн баатарлаг хүмүүсийн тухай өгүүлнэ. Кино хийх мэдээллээ Ухань хотоос авч эхэлсэн” гэжээ.

СОЁЛ УРЛАГ

Консерваторийн сурагчид сонгодог урлагийн онлайн тоглолт хийнэ

Монгол Улсын Консерваторын зүгээс авъяаслаг багш, сурагчдынхаа онцгой бүтээлүүдийг цахимаар болон телевизээр өдөр бүр толилуулан соёл урлаг, сонгодог бүтээлүүдээр ард иргэдийн алжаал ядаргааг тайлахаар болжээ. Мөн World Music онлайн фестивалийг эхлүүлж байгаа аж. Энэ талаар тус сургуулийнхан “Өдөр бүр мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр коронавирусийн халдварын мэдээлэл цацагдаж байгаа нь мэдээллийн дарангуйлалд өртөхөд хүргэж байна. Тиймээс урлагаар дамжуулан сэтгэл засах, тайвшруулах үүднээс дэлхийн болон Монголын сонгодог бүтээлүүдийг тоглоно” хэмээн онцолжээ.

Төв телевизээр Guys-ийн залуус онлайн тоглолт хийнэ

Коронавирусээс урьдчилан сэргийлж гэртээ байгаа хүмүүст контент хандивлаж, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх зорилгоор Guys хамтлаг МҮОНТВ-ээр шилдэг бүтээлүүдээ түүвэрлэн хоёр удаагийн тоглолт хүргэхээр болжээ. Тэд энэ сарын 28-ны 12:00 цагт үзэгчидтэй уулзах бөгөөд эхний тоглолтоо “Хайрын бүжиг” хэмээн нэрлэсэн байна. Харин 29-ний 12:00 цагт болох тоглолтыг “Амьдрал үргэлж сайхнаараа” бүтээлээрээ нэрлэв. Энэ үеэр үзэгчдэд гараа сайтар угаахын сацуу маск тогтмол зүүж, COVID-19 цар тахлаас урьдчилан сэргийлэхийг уриалах аж.